

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 7455 дугаарт бүртгэв.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 11 дүгээр
сарын 28-ны өдөр

Дугаар 10/09

Арвайхээр сум

МАЛ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН НОРМАТИВ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.14 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсэг, 34.2.2.1 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Орон нутгийн төсвийн санхүүжилтээр хийгдэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын нормативыг нэгдүгээр, лабораторийн оношилгоо, шинжилгээний зардлын нормативыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан нормативыг мөрдүүлж, удирдлага зохицуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга О.Пүрэвдоржид даалгасугай.

3.Энэхүү тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

4.Тогтоолыг дагаж мөрдсөн өдрөөс аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 45 дугаар тогтоол, 2015 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 10/02 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Т.НАРАНГАРАВ

*Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн
10/09 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт*

МАЛ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН НОРМАТИВ

№	Ажил үйлчилгээний нэр, төрөл	Хэмжих нэгж,	Нэгж үнэ /төгрөг/
Нэг. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга хийх			
1	Бод (тэмээ, адуу, үхэр, сарлаг)	Толгой	1000
2	Бог (хонь, ямаа)	Толгой	350
3	Амьтан (гахай, нохой, муур, шувуу)	Толгой	1000
Хоёр. Мал, амьтанд эрүүл мэндийн үзлэг хийх			
4	Бод (тэмээ, адуу, үхэр, сарлаг)	Толгой тутамд	2000
5	Бог (хонь, ямаа)	Толгой тутамд	1000
6	Гахай, шувуу бусад тэжээвэр амьтад	Толгой тутамд	2000
7	Сүргийн эрүүл мэндийн үзлэг / өрхөөр/	Бод/нийт сүрэг/	36000
		Бог/нийт сүрэг/	31000
Гурав. Лабораторийн шинжилгээнд сорьц авах			
8	Цусны сорьц (тэмээ, адуу, үхэр, сарлаг)	Толгой тутамд	2000
9	Цусны сорьц(хонь, ямаа, гахай, шувуу бусад тэжээвэр амьтад)	Толгой тутамд	1500
10	Эд, эмгэгт эдийн дээж авах	Толгой тутамд	5000
11	Баасны сорьц	Толгой тутамд	1500
12	Лабораторийн нөхцөлд эмгэг анатомийн задлан шинжилгээ хийх	Толгой тутамд	30000
13	Хээрийн нөхцөлд эмгэг анатомийн задлан шинжилгээ хийх	Толгой тутамд	20000
14	Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнээс сорьц авах	Сорьц тутамд	1500
Дөрөв. Ариутгал, халдваргүйтгэл			
15	Суудлын машин	Ширхэг	4000
16	Ачааны 40тн хүртэл, трактор г.м	Ширхэг	6000
17	Малын тэжээлийн онгоц, бусад тоног хэрэгсэл /ширхэг/	Ширхэг	3000
18	Урьдчилан сэргийлэх зорилгоор: Задгай талбайг ДУК, мотопомпоор шүрших: Битүү орчин мананцаржуулах	М.кв	190
19	Өвчний голомтыг устгах зорилгоор: Задгай талбайг ДУК, мотопомпоор шүрших, Битүү орчин мананцаржуулах	М.кв	250
Тав. Төрөл бүрийн эмийн бодис олгох			
20	Булчин. арьсан дор. арьсан дотор тариа хийх	Тэжээвэр амьтан	1000

		Шувуу	1000
		Бод	1000
		Бог	400
21	Судас мөгөөрсөн хоолойд тариа хийх	Бод	4000
		Бог	2000
22	Цээж хэвлийн хөндийд тариа хийх	Бод	4000
		бог	2000
23	Агаар дуслын эмчилгээ хийх	Бод	2000
Зургаа . Мал эмнэлгийн дуудлага үйлчилгээ			
24	Автомашинаар	Км	700
25	Мотоциклоор	Км	500
26	Зөвлөгөө өгөх	Тухай бүр	5000
Долоо. Параазиттах өвчний эсрэг арга хэмжээ			
		Бод	900
		Бог	450
27	Туулгалт	Гэрийн тэжээвэр амьтан	4000
		Бод	600
28	Боловсруулалт	Бог	300
		Бод	1200
29	Угаалга /банн/	Бог	700
		Бод	1500
30	Угаалга /шүрших/	Бог	700
Найм. Халдваргүй өвчний эмчилгээ			
31	Эх барихын тусламж	Толгой тутамд	Бод-30000, Бог-15000
32	Эвэр туурай засах	Толгой тутамд	10000
33	Хаг гардан салгах	Толгой тутамд	Бод-30000, Бог-10000
34	Хугарсан ясанд боолт хийх	Толгой тутамд	12000
35	Клизм тавих	Толгой тутамд	Бод-12000, Бог-4000
36	Сав угаах	Толгой тутамд	Бод-10000, Бог-8000
37	Оёдол тавих	Толгой тутамд	10000
38	Шүд авах	Толгой тутамд	30000
39	Сав, шулуун гэдэс тайрах	Толгой тутамд	Бод-30000, Бог-20000
		Бог, тэжээвэр амьтан	60000
40	Ксерево хагалгаа	Бод	120000

41	Эргүү эмчлэх	Толгой тутамд	Бод-30000, Бог-20000
42	Төлийн бөөм авах	Толгой тутамд	Бод-25000, Бог-15000
43	Ивэрхий эмчлэх	Толгой тутамд	Бод-30000, Бог-20000
44	Ходоод, гүзээнээс гадны биет авах	Толгой тутамд	Бод-40000, Бог-20000
45	Нохойд чихний засал хийх	Толгой тутамд	15000
46	Өндгөвч, сав боох ажилбар	Толгой тутамд	60000
47	Нохой засах ажилбар	Толгой тутамд	50000
48	Бод мал хөнгөлөх ажилбар	Толгой тутамд	40000
49	Бог мал хөнгөлөх ажилбар	Толгой тутамд	20000

*Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн
10/09 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт*

**ЛАБОРАТОРИЙН ОНОШИЛГОО, ШИНЖИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН
НОРМАТИВ**

№	Ажил үйлчилгээний нэр, төрөл	Шинжилгээний төрөл	Хэмжих нэгж	Нэгж үнэ /төгрөг/
Нэг. Ийлдэс судлалын шинжилгээ				
1	Түргэн оношлуур	Нийлүүлгийн өвчин	Нэг сорьц	20,000
2	РБУ оношлуур	Бруцеллэз өвчин	Нэг сорьц	1,000
3	ХХУ /АМЭЛ/ оношлуур	Ям өвчин	Нэг сорьц	1,0000
4	Ямблуур /оношлуур /	Ям өвчин	Нэг сорьц	1500
Хоёр. Нян судлалын оношлох шинжилгээ				
5	Түргэн тест	Боом өвчнийг илрүүлэх түргэн оношлуур	Нэг сорьц	30,000
6		ДХХ өвчнийг илрүүлэх түргэн оношлуур	Нэг сорьц	45,000
7		Галзуу өвчний үүсгэгчийг илрүүлэх	Нэг сорьц	30,000
Гурав. Шимэгч судлалын шинжилгээ / үүсгэгч илрүүлэх/				
8	Үзлэг, хөвүүлэх, дуран	Гельминттэх өвчин (кокцидиоз.- өндөг, авгалдай)	Нэг сорьц	6,000
9	Гадна шимэгч дурандах	Шимэгчтэх өвчин (хамуу, хачиг, гуур...)	Нэг сорьц	6,000
Дөрөв. Махны шинжилгээ				
10	Үлдэгдэл тодорхойлох түргэн тест (Примми, Юнисенсор)	Тетрациклиний бүлэг, стрептомицин, хлорамфеникол, беталактамын бүлэг гэх мэт	Нэг сорьц	30,000
11	рН метр	Шинэлэг байдал тодорхойлох	Нэг сорьц	3,000
12	Пероксидазын болон Формалины арга	Өвчтэй ба үхсэн малын мах ялган тодорхойлох	Нэг сорьц	5,000
13	Мэдрэхүй	Мах, махан бүтээгдэхүүнд үзлэг хийх	кг тутамд	50
Тав. Сүүний шинжилгээ				
14	Сүүний цагирган урвал	Бруцеллэз	Нэг сорьц	1,500
15	Сүүний цомог	Сүүний хольц тодорхойлох (ус, сод, гурил)	Нэг сорьц	5,000
16	Лактоскан	Сүүний найрлага /тослог, нягт, уураг, сахар, тосгүй хуурай бодис...../	Нэг сорьц	7,000
17	Түргэн оношлуур	Дэлэнгийн үрэвсэл тодорхойлох	Нэг сорьц	3,000

18	Мэдрэхүй	Сүү, Сүүн бүтээгдэхүүнд үзлэг хийх	кг, л тутамд	50
Зургаа. Мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг шинжилгээ				
19	Малын гаралтай түүхий эд, дайвар бүтээгдэхүүнд мэдрэхүйн үзлэг, шинжилгээ хийх	Малын гаралтай дайвар бүтээгдэхүүнд мэдрэхүйн үзлэг шинжилгээ хийх	Ширхэг / гогцоо/	30
20		Өндөг овоскопоор шинжлэх	Нэг сорьц	2,000
21		Бүх төрлийн мал, амьтны арьс, ширэнд мэдрэхүйн үзлэг хийх	Ширхэг	100
22		Арьс, шир, ноос, ноолууранд асколын шинжилгээ хийх	Нэг сорьц	5000

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 7456 дугаарт бүртгэв.

БОЛОВСРОЛЫН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 11 дүгээр
сарын 27-ны өдөр

Дугаар А/559

Улаанбаатар
хот

ЖУРАМ, ШААРДЛАГА БАТЛАХ ТУХАЙ

Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.8 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.“Мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх журам”-ыг нэгдүгээр, “Мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийх шинжээчид тавих шаардлага”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү тушаалын хавсралтаар баталсан журам, шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллах, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн “Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам, шалгуур шаардлага батлах тухай” 08 дугаар тогтоолыг хүчингүй болгох ажлыг зохион байгуулахыг Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл (Б.Амарсанаа)-д даалгасугай.

3.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2016 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн “Шаардлага, шалгуур үзүүлэлт тогтоох тухай” А/53 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Л.Төгсбаяр)-т даалгасугай.

САЙД

П.НАРАНБАЯР

*Боловсролын сайдын 2025 оны 11 дүгээр сарын 27-ны
өдрийн А/559 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт*

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН, ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА БОЛОН ХӨТӨЛБӨРИЙГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ, МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ ХИЙХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсролын сургалтын байгууллага (цаашид “сургалтын байгууллага” гэх) болон сургалтын хөтөлбөр (цаашид “хөтөлбөр” гэх)-ийг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2.Энэ журмын 1.1-д заасан үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хуулийн 17.13, 17.14, Дээд боловсролын тухай хуулийн 12.5, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8.4-т тус тус заасны дагуу магадлан итгэмжлэх эрх бүхий байгууллага (цаашид “магадлан итгэмжлэлийн байгууллага” гэх) зохион байгуулна.

1.3.Магадлан итгэмжлэлийн байгууллага нь Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль болон холбогдох стандарт, журам, шаардлагад нийцүүлэн сургалтын байгууллага болон хөтөлбөрт магадлан итгэмжлэл хийнэ.

1.4.Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.

1.4.1.хууль дээдлэх;

1.4.2.ил тод байх;

1.4.3.шударга ёсыг хангах;

1.4.4.хараат бус, бие даасан байх;

1.4.5.хариуцлагатай байх;

1.4.6.ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

1.4.7.чанарт суурилсан, тасралтгүй, үе шаттайгаар хөгжих үйл явцыг дэмжих.

Хоёр.Удирдлага, зохион байгуулалт

2.1.Боловсролын ерөнхий хуулийн 17.13-д заасан Боловсролын чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн байгууллага дараах удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.1.1.боловсролын сургалтын байгууллага, сургалтын хөтөлбөрийн чанарыг эрх бүхий байгууллагын баталсан стандарт, шаардлагын дагуу магадлан итгэмжлэх, чанарын баталгаажуулалтыг удирдлага, арга зүйгээр хангах;

2.1.2. магадлан итгэмжлэл хийх эрхийг дотоодын байгууллагад олгох, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.9-д заасны дагуу гадаадын хуулийн этгээдэд зөвшөөрөл олгох, гадаадын болон олон улсын эрх бүхий байгууллагатай хамтран магадлан итгэмжлэл хийх, олон улсад магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийг баталгаажуулах, бүртгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

2.1.3. шинжээчид тавигдах шаардлагыг хангасан иргэнд шинжээчээр ажиллах эрх олгох, чадавхыг дээшлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

2.1.4. магадлан итгэмжлэлийн хүсэлт гаргах, үйл ажиллагааны явц болон шийдвэрийн талаарх мэдээллийн бүртгэл хөтлөх, хянах, тайлагнах нэгдсэн цахим системийг хөгжүүлж ашиглах;

2.1.5. магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллага болон хөтөлбөрийн мэдээллийг энэхүү журмын 2.1.4-т заасан цахим системд хөтлөн, нийтэд ил тод байршуулах;

2.1.6. магадлан итгэмжлэл хийх үйл ажиллагааны зардлыг тооцох аргачлалыг боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах;

2.1.7. боловсролын чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэлийн мэдээ, тайланг хагас жил тутамд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

2.2. Энэхүү журмын 2.1-д зааснаас бусад магадлан итгэмжлэлийн байгууллага дараах үйл ажиллагааг зохион байгуулна.

2.2.1. батлагдсан шалгуур, шаардлагын дагуу магадлан итгэмжлэл хийх, хөндлөнгийн хараат бус шийдвэр гаргах;

2.2.2. магадлан итгэмжлэлийн шийдвэрийг энэхүү журмын 2.1.4-т заасан цахим системд байршуулж, нийтэд ил тод мэдээлэх;

2.2.3. магадлан итгэмжлэлийн шийдвэрийг хэрэгжүүлэх талаар сургалтын байгууллагад зөвлөмж өгөх, дэмжлэг үзүүлэх;

2.2.4. магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааны мэдээ тайланг хагас жил тутамд Боловсролын ерөнхий хуулийн 17.13-д заасан байгууллагад хүргүүлэх.

2.3. Сургалтын байгууллага дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.3.1. дотоод чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлж, үр дүнг бодитой үнэлэх;

2.3.2. хөндлөнгийн үнэлгээ хийсэн шинжээчийн багийн тайлан, магадлан итгэмжлэлийн комиссын зөвлөмж, шаардлагын биелэлтийг хангах;

2.3.3. магадлан итгэмжлэлийн шалгуурыг хангах, чанарыг тасралтгүй сайжруулах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх.

Гурав.Магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаа

3.1.Магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаа нь хүсэлт гаргаж гэрээ байгуулах, магадлан итгэмжлэл хийх, шийдвэр гаргах үе шаттай байна.

3.2.Хүсэлт гаргаж, гэрээ байгуулах үе шат:

3.2.1.сургалтын байгууллага магадлан итгэмжлэлийн байгууллагад сургалтын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх хүсэлт, холбогдох баримт бичгийг бүрдүүлж цахимаар ирүүлнэ;

3.2.2.магадлан итгэмжлэлийн байгууллага хүсэлт, баримт бичгийн бүрдлийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор хянан үзэж, шаардлага хангасан тохиолдолд сургалтын байгууллагатай гэрээ байгуулна;

3.2.3.энэхүү журмын 3.2.2-т заасан гэрээнд оролцогч талуудын эрх, үүрэг хариуцлага, төлбөрийн нөхцөлийг тусгаж, магадлан итгэмжлэлийн шийдвэр гаргах хүртэлх үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран батална.

3.3.Магадлан итгэмжлэл хийх үе шат:

3.3.1.магадлан итгэмжлэлийн байгууллагаас сургалтын байгууллага, хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багт зориулан сургалт зохион байгуулж, арга зүйн зөвлөмж өгнө;

3.3.2.сургалтын байгууллагын өөрийн үнэлгээний тайланг тухайн сургуулийн удирдах зөвлөл, хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг холбогдох нэгжийн хурлаар хэлэлцүүлж, гэрээнд заасан хугацаанд магадлан итгэмжлэлийн байгууллагад ирүүлнэ;

3.3.3.магадлан итгэмжлэлийн байгууллагын гүйцэтгэх удирдлага сургалтын байгууллага болон хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийх шинжээчийн багийг томилж, гэрээ байгуулна;

3.3.4.шинжээчийн багтай байгуулах гэрээнд талуудын эрх, үүрэг, хариуцлага, ажлын нөхцөл, хугацаа, ажлын хөлс, ёс зүйн хэм хэмжээ зэргийг тодорхой тусгана;

3.3.5.магадлан итгэмжлэлийн байгууллагаас сургалтын байгууллагын өөрийн үнэлгээний тайлан болон холбогдох баримт бичгийг шинжээчийн багт хүлээлгэн өгнө;

3.3.6.шинжээчийн баг сургалтын байгууллагад ажиллан магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагын хүрээнд баримт бичиг, нотолгоонд үндэслэн хөндлөнгийн үнэлгээ хийнэ;

3.3.7.үнэлгээний явцын мэдээлэл, нотолгоонд тулгуурлан багийн гишүүд хамтран шинжээчийн тайланг боловсруулна;

3.3.8.шинжээчийн баг үнэлгээний тайланг гэрээнд заасан хугацаанд магадлан итгэмжлэлийн байгууллагад ирүүлнэ.

3.4.Магадлан итгэмжлэлийн шийдвэр гаргах үе шат:

3.4.1. магадлан итгэмжлэлийн байгууллагын эрх бүхий комисс, мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн багийн үнэлгээний тайланг хэлэлцэнэ;

3.4.2. шинжээчийн баг хуралдаанд бүрэлдэхүүнээрээ оролцож, үнэлгээний тайланг танилцуулна;

3.4.3. магадлан итгэмжлэлийн байгууллагын эрх бүхий комисс, мэргэжлийн зөвлөлийн гишүүд нээлттэй санал хурааж, олонхын саналаар магадлан итгэмжлэлийн шийдвэрийг гарган, тогтоолоор баталгаажуулна;

3.4.4. магадлан итгэмжлэлийн шийдвэр дараах төрөлтэй байна. Үүнд:

3.4.4.1. магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагын 85-100 хувийг хангасан бол “магадлан итгэмжилнэ”;

3.4.4.2. магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагын 70-84 хувийг хангасан бол “нөхцөлтэйгөөр магадлан итгэмжилнэ”;

3.4.4.3. магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагын 51-69 хүртэлх хувийг хангасан бол “магадлан итгэмжлэлийг хойшлуулна”;

3.4.4.4. магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагын 50 хүртэлх хувийг хангасан бол “магадлан итгэмжлэхээс татгалзана”.

3.4.5. Дээд боловсролын тухай хуулийн 12.8-д заасны дагуу дээд боловсролын шинэ хөтөлбөрт урьдчилсан магадлан итгэмжлэл хийнэ. Урьдчилсан магадлан итгэмжлэлийн шийдвэр нь дараах төрөлтэй байна:

3.4.5.1. урьдчилсан магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагын 85-100 хувийг хангасан бол “хангасан”;

3.4.5.2. урьдчилсан магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагын 84 хүртэлх хувийг хангасан бол “хангаагүй” гэж шийдвэрлэнэ.

3.4.6. урьдчилсан магадлан итгэмжлэлийн шийдвэр тухайн хөтөлбөрөөр төгсөлт хийх хүртэл хүчинтэй байна.

3.5. Магадлан итгэмжлэлийн шийдвэрийн хугацаа:

3.5.1. “магадлан итгэмжлэл”-ийн шийдвэрийн хугацаа 5 жил байна;

3.5.2. дээд боловсролын сургалтын байгууллага гурван удаа магадлан итгэмжлэл хийлгэсэн тохиолдолд энэхүү журмын 3.4.4.1-д заасан шийдвэрийг хангаж байвал магадлан итгэмжлэлийн хугацаа 10 жил байна;

3.5.3. “нөхцөлтэй магадлан итгэмжлэл”-ийн шийдвэрийн хугацаа 2 жил байна;

3.5.4. “магадлан итгэмжлэлийг хойшлуулна” гэсэн шийдвэр гарсан бол сургалтын байгууллага 18 сарын дотор зөвлөмж,

шаардлагын дагуу ахиц дэвшлийн тайланг ирүүлж, дахин магадлан итгэмжлүүлж болно;

3.5.5.“магадлан итгэмжлэхээс татгалзана” гэж шийдвэрлэсэн тохиолдолд магадлан итгэмжлэлийг шинээр эхлүүлнэ;

3.5.6.энэхүү журмын 3.4.4.1, 3.4.4.2-т заасан шийдвэрийг үндэслэн магадлан итгэмжлэх байгууллагын гүйцэтгэх удирдлага магадлан итгэмжлэлийн батламж олгоно;

3.5.7.“нөхцөлтэй магадлан итгэмжлэл”-ийн хугацаанд дахин магадлан итгэмжлэл хийлгэж “магадлан итгэмжилнэ” гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэхүү журмын 3.5.1-д заасан хугацаанд өмнөх шийдвэрийн хугацааг багтаан тооцож, магадлан итгэмжлэлийн давтамжийг тогтооно;

3.5.8.магадлан итгэмжлэлийн шийдвэрийн хугацаа дуусахаас 12 сарын өмнө дахин магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргана.

Дөрөв.Магадлан итгэмжлэлийн шийдвэрийн дараах үйл ажиллагаа

4.1.Магадлан итгэмжлэлийн байгууллага сургалтын байгууллага, хөтөлбөрийн чанарын ахиц дэвшлийн тайланг цахим системээр хүлээн авч, дүн шинжилгээ хийж, холбогдох зөвлөмж өгч ажиллана.

4.2.Сургалтын байгууллага магадлан итгэмжлэлийн шийдвэрт заасан хугацаанд чанарын ахиц дэвшлийн тайланг магадлан итгэмжлэлийн байгууллагад хүргүүлнэ.

4.3.Энэхүү журмын 4.2-т заасан чанарын ахиц дэвшлийн тайланг тогтоосон хугацаанд ирүүлээгүй, эсвэл сургалтын байгууллага болон хөтөлбөрийн чанарт ахиц дэвшил гараагүй бол магадлан итгэмжлэлийн шийдвэрт өөрчлөлт оруулах үндэслэл болно.

Тав.Магадлан итгэмжилсэн шийдвэрт өөрчлөлт оруулах

5.1.Магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллага болон хөтөлбөрийн шалгуур, шаардлагыг хангахад нөлөөлөхүйц өөрчлөлт орсон тухай бүрд мэдээллийг сургалтын байгууллага албан бичгээр баталгаажуулан магадлан итгэмжлэлийн байгууллагад ирүүлнэ.

5.2.Энэхүү журмын 5.1-д заасан мэдээлэлд үндэслэн магадлан итгэмжлэлийн хүчин төгөлдөр байдлын талаар магадлан итгэмжлэлийн байгууллага эрх бүхий комисс, мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шийдвэр гаргана.

Зургаа.Хариуцлага, гомдол гаргах

6.1.Сургалтын байгууллага магадлан итгэмжлэлийн шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш нэг сарын дотор шийдвэртэй холбоотой гомдлыг магадлан итгэмжлэлийн байгууллагад гаргах эрхтэй.

6.2.Магадлан итгэмжлэлийн байгууллагаас гаргасан шийдвэр болон үйл ажиллагаатай холбоотой гомдлыг Боловсролын ерөнхий

хуулийн 17.13-д заасан байгууллагад гаргана.

6.3.Боловсролын ерөнхий хуулийн 17.13-д заасан байгууллагын эрх бүхий комиссын шийдвэр гаргах үйл явцад гомдлыг үнэлгээ хийгдсэн нотлох баримтын хүрээнд хянан үзнэ.

6.4.Гомдлыг хэлэлцэх хуралдаанд шаардлагатай гэж үзвэл сургалтын байгууллагын төлөөллийг оролцуулж болно.

*Боловсролын сайдын 2025 оны 11 дүгээр сарын 27-ны
өдрийн А/559 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт*

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН, ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА БОЛОН ХӨТӨЛБӨРИЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ ХИЙХ ШИНЖЭЭЧИД ТАВИХ ШААРДЛАГА

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Магадлан итгэмжлэлийн байгууллагаас мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийх шинжээч (цаашид “шинжээч” гэх)-ийг сонгон шалгаруулахад энэхүү шаардлагыг баримтална.

1.2.Мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийх шинжээчийг ажиллуулахтай холбоотой үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хуулийн 17.13-д заасан байгууллага удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллана.

1.3.Шинжээч тодорхой салбар, судалгааны чиглэлээр мэдлэг, ур чадвар, туршлагатай, сургалтын байгууллага болон хөтөлбөрт хараат бус магадлан итгэмжлэл хийх, шийдвэр гаргах чадвартай шинжээчийн эрх олгох сургалтад хамрагдсан иргэн байна.

Хоёр.Шинжээчид тавих ерөнхий шаардлага

2.1.Шинжээч нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

2.1.1.дээд боловсролтой байх;

2.1.2.мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх;

2.1.3.мэргэшлийн зэрэг эсхүл эрдмийн зэрэг, цолтой байх;

2.1.4.боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх, багаар ажиллаж, асуудал шийдвэрлэх чадвартай байх;

2.1.5.ял шийтгэлгүй байх;

2.1.6.ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй байх;

2.1.7.авлига, ашиг сонирхлын зөрчилгүй байх.

2.2.Шинжээч нь дараах мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байна:

2.2.1.гадаад хэлний зохих мэдлэгтэй байх;

2.2.2.судалгаа, шинжилгээний арга зүй эзэмшсэн байх;

2.2.3.боловсролын салбарын холбогдох хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан хэм хэмжээний актын хэрэглээний мэдлэг ур чадвартай байх;

2.2.4.мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц, эрдмийн зэрэг харилцан хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэх болон кредит системийн талаарх мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байх;

2.2.5.сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүй, үнэлгээний мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байх;

2.2.6.чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэлийн чиглэлээр үнэлгээ хийх баримт бичиг, дотоодын болон олон улсын арга аргачлалыг хэрэглэх чадвартай байх;

2.2.7.боловсролын салбарын хөгжил, хөдөлмөрийн зах зээлийн хэтийн төлөв, чиг хандлагын талаарх ойлголт, мэдлэг, ур чадвартай байх.

Гурав.Шинжээчид тавих тусгай шаардлага

3.1.Дээд боловсролын сургалтын байгууллагад магадлан итгэмжлэл хийх шинжээчид тавих шаардлага:

3.1.1.доктор ба түүнээс дээш эрдмийн зэрэг, цолтой байх;

3.1.2.магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролын сургалтын байгууллага болон эрдэм шинжилгээний байгууллагад 10-аас доошгүй жил, үүнээс дэд профессорын ангиллын албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх;

3.1.3.дээд боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновац, сургуулийн үйл ажиллагааны чиглэлээр урт болон дунд хугацааны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлдэг байх;

3.1.4.зөвлөх үйлчилгээ, эрдэм шинжилгээ, судалгаа, хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлсэн байх;

3.1.5.эрдэм шинжилгээ, сургалт, мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлээр патент, зохиогчийн эрх эсвэл ашигтай загварын гэрчилгээ авсан байх;

3.1.6.олон улсын мэдээллийн санд бүртгэлтэй хянан магадалгаа хийгддэг мэргэжлийн сэтгүүлд хоёроос доошгүй эрдэм шинжилгээний өгүүллийг нэгдүгээр эсвэл холбоо баригч зохиогчоор хэвлүүлсэн байх.

3.2.Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт магадлан итгэмжлэл хийх шинжээчид тавих шаардлага:

3.2.1.доктор ба түүнээс дээш эрдмийн зэрэг, цолтой байх;

3.2.2.сургалтын хөтөлбөрийн цогц баримт бичгийг боловсруулах арга зүй эзэмшсэн байх;

3.2.3.судалгааны ажил, ном, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл хэвлэн нийтлүүлсэн байх;

3.2.4.сургалтын технологи, кредит систем, чанарын баталгаажуулалтын чиглэлээр сургалтад хамрагдсан байх;

3.2.5.байгууллага, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний баг эсвэл судалгааны багт ажилласан туршлагатай байх;

3.2.6.сургалтын хөтөлбөр боловсруулах, ажлын байран дахь зайн болон цахим сургалтыг хэрэгжүүлэх туршлагатай.

3.3.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх шинжээчид тавих шаардлага:

3.3.1.магистр, түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;

3.3.2.боловсролын сургалтын байгууллагын удирдах ажилтан болон тэргүүлэх түүнээс дээш зэрэгтэй багш, албан хаагч байх;

3.3.3.мэргэжлийн болон техникийн боловсролын чиглэлээр гадаад, дотоодод урт, богино хугацааны сургалтад хамрагдсан, судалгаа, шинжилгээ хийж байсан туршлагатай байх;

3.3.4.зөвлөх үйлчилгээ, эрдэм шинжилгээ, судалгаа, хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлсэн байх.

3.4.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрт магадлан итгэмжлэл хийх шинжээчид тавих шаардлага:

3.4.1.магистр, түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх эсхүл мэргэшлийн өндөр ур чадвартай байх;

3.4.2.сургалтын хөтөлбөрийн цогц баримт бичиг эсвэл ажил мэргэжлийн стандарт боловсруулах арга зүй эзэмшсэн байх;

3.4.3.мэргэжлийн чиглэлээр боловсролын сургалтын болон эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн холбоод, танхим, үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан байх;

3.4.4.боловсрол судлал болон мэргэжлийн чиглэлээр судалгааны ажил, ном, сурах бичиг, гарын авлага, илтгэл, өгүүлэл хэвлэн нийтлүүлсэн байх;

3.4.5.сургалт, үнэлгээ, ажил мэргэжлийн стандарт, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулахад гар бие оролцсон байх.

Дөрөв.Бусад

4.1.Боловсролын ерөнхий хуулийн 17.13-д заасан байгууллагаас “Шинжээчийн ажиллах журам”-ыг баталж, мөрдүүлнэ.

4.2.Дараах болзлыг хангасан тохиолдолд шинжээчээр ажиллуулж болно:

4.2.1.олон улсад магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллага, хөтөлбөрийн өөрийн үнэлгээний баг ахалсан албан тушаалтан байх;

4.2.2.олон улсын шинжээч байх;

4.2.3.дэлхийн ур чадварын тэмцээний эксперт багш байх.

4.3.Сургалтын байгууллага, хөтөлбөрийг магадлан итгэмжлэх шинжээчийн багт ажиллах номын санч, эдийн засагч, санхүүч, сэтгэл зүйч, хуульч, ажил олгогч, оюутан, суралцагчийн төлөөлөлд тавигдах шаардлагыг энэхүү журмын 4.1-д заасан журмаар зохицуулна.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 7457 дугаарт бүртгэв.

СЭЛЭНГЭ АЙМАГ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 9 дүгээр
сарын 17-ны өдөр

Дугаар 47

Сүхбаатар сум

ОРОН НУТГИЙН, ХОТ ДОТОРХ БОЛОН ХОТ ОРЧМЫН НИЙТИЙН ЗОРЧИГЧ ТЭЭВЭР, ТАКСИ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.14 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Орон нутгийн, хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тэмдэгтийн хураамжийн хэмжээг 3.000.000 (гурван сая) төгрөгөөр тогтоосугай.

2.Улсын тэмдэгтийн хураамжийг тогтоосон хэмжээний дагуу мөрдүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Н.Лхагвадорж)-д даалгасугай.

3.Тогтоолыг Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга (Э.Оюунболд)-д даалгасугай.

ДАРГА

Г.БАТ-ОРХОН

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 126

Улаанбаатар
хот

УЛААНБААТАР ХОТЫН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын цэвэр, бохир усны үйлчилгээний хүн амын тарифыг нэгдүгээр, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын тарифыг хоёрдугаар, зөөврийн ус хангамж, бохир ус зөөврөөр татан зайлуулах үйлчилгээний тарифыг гуравдугаар, хэрэглэгчдийн цэвэр, бохир усны үйлчилгээний суурь хураамжийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэний дараах сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, хэрэглэгчдийг мэдээллээр хангаж ажиллахыг Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч/цаашид "ТЗЭ" гэх/аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, үргүй зардал, усны алдагдлыг бууруулж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг ТЗЭ аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах хорооны 2017 оны 91 дүгээр тогтоол, 2019 оны 23 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт, 2023 оны 96 дугаар тогтоолыг дээр дурдсан мөрдөж эхлэх хугацаанаас тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг
Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЦОГТСАЙХАН

ГИШҮҮН

Б.АЛТАНТУУЛ

Д.АНХБАТ

Ц.БАТЗАЯА

Т.УЛАМБАЯР

*Хот, суурины ус хангамж, ариутгах таттуургын ашиглалт,
үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны 12 дугаар сарын 11-ний
өдрийн 126 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт*

**УЛААНБААТАР ХОТЫН ХҮН АМД МӨРДӨХ ЦЭВЭР, БОХИР УСНЫ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ
(НӨАТ-ГҮЙ)**

№	Үйлчилгээний төрөл		Хэмжих нэгж	Тариф
1.	Цэвэр ус	Тоолууртай	төг/л	2.00
		Тоолуургүй	төг/л	2.97
2.	Бохир ус	Тоолууртай	төг/л	1.82
		Тоолуургүй	төг/л	2.65

*Хот, суурины ус хангамж, ариутгах татнуур, ашиглалт,
үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны 12 дугаар сарын 11-ний
өдрийн 126 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт*

**УЛААНБААТАР ХОТЫН ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГАД МӨРДӨХ ЦЭВЭР, БОХИР УСНЫ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ
(НӨАТ-ГҮЙ)**

№	Үйлчилгээний төрөл		Хэмжих нэгж	Тариф
1.	Цэвэр ус	Доор дурдсанаас бусад үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага	төг/л	3.50
		Төсөвт байгууллага	төг/л	4.40
		Спирт, архи, пиво, ундаа, усны үйлдвэр, машин угаалга	төг/л	4.94
		Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр	төг/л	3.60
2.	Бохир ус	Доор дурдсанаас бусад үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага	төг/л	3.20
		Төсөвт байгууллага	төг/л	4.00
		Спирт, архи, пиво, усны үйлдвэр, мах, сүү, талх нарийн боов, эмнэлэг	төг/л	4.30
		Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр, машин угаалга	төг/л	5.50
3.	Урьдчилан цэвэрлэх байгууламжийн бохир ус цэвэрлэх үйлчилгээ		төг/л	4.0

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 126 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

**УЛААНБААТАР ХОТЫН ЗӨӨВРИЙН УС ХАНГАМЖ, БОХИР УС
ЗӨӨВРӨӨР ТАТАН ЗАЙЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ
(НӨАТ-ГҮЙ)**

№	Үйлчилгээний төрөл		Хэмжих нэгж	Тариф
1.	Цэвэр ус	Төвлөрсөн шугамын ус түгээх байр	төг/л	1.82
		Зөөврийн ус түгээх байр	төг/л	1.82
		Зуслангийн болон алслагдсан зориулалтын цэгт	төг/л	5.45
		Үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагад	төг/л	5.45
2.	Бохир ус	Цооногтой айл өрх	төг/л	1.5
		Цооногтой үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага	төг/л	2.50

*Тайлбар: Үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагад, Цооногтой айл өрх, Цооногтой үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага зэрэг ангиллуудад тээврийн зардал ороогүй болно.

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт,
үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны 12 дугаар сарын 11-ний
өдрийн 126 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт*

**УЛААНБААТАР ХОТЫН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
СУУРЬ ХУРААМЖ**

**Нэг. Хүн ам
(НӨАТ-гүй)**

Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Цэвэр	Бохир
Айл өрх	төг/сар	3,125	625

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(төгрөг/сар, НӨАТ-гүй)**

№	Оролтын шугамын голч (мм)	Цэвэр ус	Бохир ус
1.	15	6,600	1,500
2.	20	9,000	1,800
3.	25	13,800	2,700
4.	32	20,520	4,050
5.	40	30,600	6,000
6.	50	48,120	9,600
7.	65	59,760	11,850
8.	80	79,080	15,750
9.	100	114,600	22,920
10.	125	139,800	27,600
11.	150	189,720	37,800
12.	200	234,000	46,800
13.	250	322,560	64,500
14.	300	426,600	85,200
15.	400=<	576,000	115,200

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 25/06

Өлгий

ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол улсын Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 67.2 дах хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 504 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн, Баян-Өлгий аймгийн Цагааннуур тосгоны “Нурдуман” ХХК-ийн 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 165 тоот албан хүсэлтийг хянан хэлэлцээд аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Баян-Өлгий аймгийн Цагааннуур тосгоны “Нурдуман” ХХК -ийн эзэмшлийн дулаан түгээх шугам сүлжээнд холбогдсон төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан тарифыг «Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл»-д нийтлүүлэн, тогтоолыг 2026 оны 01 сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.

3.Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн тарифыг мөрдөж ажиллахыг «Нурдуман” ХХК (С.Жухай)-д, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн гишүүд / К.Бахытжан, М.Дауренбек /-д даалгасугай.

4.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Аймгийн зохицуулах зөвлөлийн “Тариф батлах тухай” 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 22/06 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА

Х.ХАРЛЫГАШ

ЗОХИЦУУЛАГЧ
ЗОХИЦУУЛАГЧ

К.БАХЫТЖАН
М.ДАУРЕНБЕК

*Баян-Өлгий аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн
2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
25/06 дугаар тогтоолын хавсралт*

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЦАГААНУУР ТОСГОНЫ ХЭРЭГЛЭГЧДЭД
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

1.Баян-Өлгий аймгийн Цагааннуур тосгоны хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф /НӨАТ-гүй/-ыг ангиллаас хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно. Үүнд:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м ³	1,890.0
	Төсөвт байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Төг/ГЖ	21,834.2
2	Үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м ³	1,700.0
	Үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Төг/ГЖ	19,621.4
3	Сургуулийн дотуур байрны хүүхэд амьдрах хэсгийн талбайгаар тооцох халаалт	Төг/м ²	2,700.0
	Сургуулийн дотуур байрны хүүхэд амьдрах хэсгийн талбайгаар тооцох халаалт	Төг/ГЖ	31,388.8
	Орон сууцны барилга (зоорины давхар, "0"-ын өрөөний халаалт хамаарна)	Төг/м ²	1700.0
	Орон сууцны барилга (зоорины давхар, "0"-ын өрөөний халаалт хамаарна)	Төг/ГЖ	19,621.4
4	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/хүн	1800

ХОВД АЙМГИЙН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 10

Ховд

“ЖАРГАЛАНТ БУД ТРЕЙД” ХХК-НИЙ ҮНЭ ТАРИФЫГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалт, Жаргалант сумын төвийг дулаанаар хангагч “Бадамлах дөл” ХХК-аас ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн Зохицуулах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Буянт сумын төвийг дулаанаар ханган ажиллаж буй “Жаргалант буд трейд” ХХК-ийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон төсөвт байгууллага, аж ахуй нэгж, айл өрхийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан тарифыг “Захиргааны хэм хэмжээний акт”-д бүртгүүлж, 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг зохицуулах зөвлөлийн дарга бөгөөд орон тооны гишүүн /Б.Гомбосүрэн/, Жаргалант буд трейд ХХК-ний ерөнхий захирал /Т.Энхбат/-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тариф батлах тухай 2023 оны 12 дугаар сарын 25 өдрийн 26 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тогтоолын биелэлтийг хангуулах, хяналт тавьж ажиллахыг орон тооны бус гишүүд Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Анхбаяр/, Эрчим хүчний улсын байцаагч /З.Батзаяа/-д тус тус даалгасугай.

ДАРГА

Б.ГОМБОСҮРЭН

ГИШҮҮН

Б.АНХБАЯР

ГИШҮҮН

З.БАТЗАЯА

*Зохицуулах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 4-ний
өдрийн 10 дугаар тогтоолын хавсралт*

**ДУЛААНЫ “ЖАРГАЛАНТ БУД ТРЕЙД” ХХК-н ЭЗЭМШЛИЙН
ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДЭД
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Ховд аймгийн Жаргалант сумын “Жаргалант буд трейд” ХХК-ний эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг /неат-гүй/ ангилалаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно.

№	Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /неат-гүй/
1	Төсөвт байгууллагуудын халаалт	Төг/м3	1885.0
2	Үйлдвэр, аж ахуй нэгж байгууллагын халаалт	Төг/м3	1350.0
3	Айл өрхийн халаалт	Төг/хүн	800.0
4	Ахуйн хэрэглээний халуун ус халаасан дулаан	Төг/м3	2000.0
5		Төг/хүн	6000.0

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 08/25

Мөрөн

ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 заалт, 26 дүгээр зүйлийн 26.2 заалт, Захиргааны еранхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Эрчим Хүчний зохицуулах хорооны 231 дүгээр тогтоолоор баталсан “Цахилгаан дулааны эрчим хүчний үнэ тарифыг тогтоох аргачлал”, “Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тарифын саналыг хянах, шалгах журам” болон Нүхт Дулаан ХХК, Их-Уул дулаан ХХК, Хөвсгөл Тэвхэн ХХК-ийн хүсэлтүүд, Хөвсгөл Эрчим Хүчний Зохицуулах Зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Их-Уул дулаан” ХХК-ийн халаалтын зуухны дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний тарифыг хавсралт №01, “Нүхт дулаан” ХХК-ийн дулааны эрчим хүчний тарифыг хавсралт №02, “Хөвсгөл Тэвхэн” ХХК-ийн дулааны эрчим хүчний тарифыг хавсралт №03 тус тус жагсаалтад зааснаар баталсугай.

2.Тариф шинэчлэн тогтоосон тухай шаардлагатай материалыг бүрдүүлэн ХЗДХЯамны Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд бүртгүүлэхийг зөвлөлийн орон тооны гишүүн /Ч.Баярсайхан/ - д даалгасугай.

3.Тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүргэгдэн баталжаасан үеэс тогтоосон тарифыг мөрдөж эхлэхийг дээрх нэр бүхий Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн захирал, дарга нарт зөвшөөрсүгэй.

4.Шинээр баталсан тарифыг захиргааны хэм хэмжээний актад бүртгүүлсэн өдрөөс эхлэн дээрх нэр бүхий тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мөрдөж байсан Хөвсгөл Эрчим Хүчний Зохицуулах Зөвлөлийн 2022 оны 04 сарын 13-ны өдрийн 07 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.

5.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Зөвлөлийн орон тооны гишүүн /Ч.Баярсайхан/, орон тооны бус гишүүн ЭХХУБайцаагч /Д.Аюушжав/ нарт даалгасугай.

ДАРГА

Ч.БАЯРСАЙХАН

ГИШҮҮН

Д.АЮУШЖАВ

ГИШҮҮН

Б.БАЗАРДАМБУУ

*Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн
2025 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн
08/25 дгаар тогтоолын хавсралт 1*

**“ИХ-УУЛ ДУЛААН” ХХК-ИЙН ХАЛААЛТЫН ЗУУХНЫ ДУЛААН
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДИЙН ДУЛААНЫ
ТАРИФ**

№	Байгууллага	ТЗЭ-ийн мөрдөж буй тариф	ТЗЭ-ээс ирүүлсэн тарифын санал	ЭХЗЗ-ийн оруулсан санал	Баталсан нь /НӨАТ-гүй/
1	Айл өрх	450	1000	900	900
2	ААНэгж байгууллага	750	1500	1350	1350
3	Төсөвт байгууллага	1580	2500	1960	1960

*Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн
2025 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн
08/25 дгаар тогтоолын хавсралт 2*

**“НҮХТ ДУЛААН” ХХК-ИЙН ХАЛААЛТЫН ЗУУХНЫ ДУЛААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДИЙН ДУЛААНЫ ТАРИФ**

№	Байгууллага	ТЗЭ-ийн мөрдөж буй тариф	ТЗЭ-ээс ирүүлсэн тарифын санал	ЭХЗЗ-ийн хуралд оруулсан санал	Баталсан нь /НӨАТ-гүй/
1	Айл өрх	400	900	900	900
2	ААНэгж байгууллага	850	1274	1250	1300
3	Төсөвт байгууллага	1580	2370	1950	2070

*Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн
2025 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн
08/25 дгаар тогтоолын хавсралт 3*

**“ХӨВСГӨЛ ТЭВХЭН” ХХК-ИЙН ХАЛААЛТЫН ЗУУХНЫ ДУЛААН
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДИЙН ДУЛААНЫ
ТАРИФ**

№	Байгууллага	ТЗЭ-ийн мөрдөж буй тариф	ТЗЭ-ээс ирүүлсэн тарифын санал	ЭХЗЗ-ийн оруулсан санал	Баталсан нь /НӨАТ-гүй/
1	Айл өрх	600	800	700	700
2	ААНэгж байгууллага	1200	1300	1300	1300
3	Төсөвт байгууллага	..		..	

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 7462 дугаарт бүртгэв.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 09/25

Мөрөн

ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 заалт, 26 дүгээр зүйлийн 26.2 заалт, Захиргааны еранхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Эрчим Хүчний зохицуулах хорооны 231 дүгээр тогтоолоор баталсан “Цахилгаан дулааны эрчим хүчний үнэ тарифыг тогтоох аргачлал”, “Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тарифын саналыг хянах, шалгах журам” болон “Дүгийн Эх” ОНӨААТҮГ-ийн хүсэлт, Хөвсгөл эрчим хүчний зохицуулах зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дулааны эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийг шинээр авсан дор дурьдсан хуулийн этгээдийн дулааны эрчим хүч хэрэглэгчдэд борлуулах тарифыг аймгийн зохицуулах зөвлөлийн тооцон хянасаныг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлэн мөрдсүгэй. Үүнд:

1.1. “Дүгийн Эх” ОНӨААТҮГ-ийн халаалтын зуухны дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний тарифыг хавсралт №01 жагсаалтад зааснаар баталсугай.

2. Уг тарифын шаардлагатай материалыг бүрдүүлэн ХЗДХЯамны Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд бүртгүүлэхийг зөвлөлийн орон тооны гишүүн /Ч.Баярсайхан/ - д даалгасугай.

3. Шинээр баталсан тарифыг захиргааны хэм хэмжээний актад бүртгүүлсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Дүгийн Эх” ОНӨААТҮГ-ийн захирал /Б.Эрдэнэцогт/-д зөвшөөрсүгэй.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Зөвлөлийн орон тооны гишүүн /Ч.Баярсайхан/, орон тооны бус гишүүн ЭХХУБайцаагч /Д.Аюушжав/ нарт даалгасугай.

ДАРГА

Ч.БАЯРСАЙХАН

ГИШҮҮН
ГИШҮҮН

Д.АЮУШЖАВ
Б.БАЗАРДАМБУУ

*Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн
2025 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн
тогтоолын хавсралт*

**“ДҮГИЙН ЭХ” ОНӨААТҮГ-ИЙН ХАЛААЛТЫН ЗУУХНЫ ДУЛААН
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДИЙН ДУЛААНЫ
ТАРИФ**

№	Байгууллага	ТЗЭ-ийн мөрдөж буй тариф	ТЗЭ-ээс ирүүлсэн тарифын санал	ЭХЗЗ-ийн оруулсан санал	Баталсан нь /НӨАТ-гүй/
1	Айл өрх		900	900	900
2	ААНэгж байгууллага		1700	1700	1700
3	Төсөвт байгууллага		2250	2200	2200

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 7463 дугаарт бүртгэв.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 03-ны өдөр

Дугаар 10/25

Мөрөн

ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 заалт, 26 дүгээр зүйлийн 26.2 заалт, Захиргааны еранхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 1/2242 дугаар албан даалгавар, Эрчим Хүчний зохицуулах хорооны 2025 оны 05 дугаар сарын 15-ны 01/464 дугаар зөвлөмж, Хөвсгөл эрчим хүчний зохицуулах зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дулааны эрчим хүч үйлдвэрлэгч дор дурьдсан хуулийн этгээдийн дулаан хэрэглэгчдэд борлуулж байгаа аймгийн зохицуулах зөвлөлийн 2017 онд баталсан дулааны тарифыг өөрчлөлтгүйгээр батлан захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлэн мөрдсүгэй. Үүнд:

1.1. “Идэр нумт” ХХК-ийн дулааны эрчим хүчний тарифыг хавсралт №01-; жагсаалтад зааснаар баталсугай.

2. Уг тарифын шаардлагатай материалыг бүрдүүлэн Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд бүртгүүлэхийг зөвлөлийн орон тооны гишүүн /Ч.Баярсайхан/ - д даалгасугай.

3. Шинээр баталсан тарифыг захиргааны хэм хэмжээний актад бүртгүүлсэн өдрөөс Хөвсгөл Эрчим Хүчний Зохицуулах Зөвлөлийн 2017 оны 08 сарын 04-ны өдрийн 04 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Зөвлөлийн орон тооны гишүүн /Ч.Баярсайхан/, Орон тооны бус гишүүн ЭХХУБайцаагч /Д.Аюушжав/ нарт даалгасугай.

ДАРГА

Ч.БАЯРСАЙХАН

ГИШҮҮН
ГИШҮҮН

Д.АЮУШЖАВ
Б.БАЗАРДАМБУУ

*Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн
2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн
тогтоолын хавсралт 01*

**“ИДЭР НУМТ” ХХК-ИЙН ХАЛААЛТЫН ЗУУХНЫ ДУЛААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ТАРИФ**

№	Байгууллага	ТЗЭ-ийн мөрдөж буй тариф	ТЗЭ-ээс ирүүлсэн тарифын санал	ЭХЗЗ-ийн баталсан тариф
1	Айл өрх	250		250
2	ААНэгж байгууллага	700		700
3	Төсөвт байгууллага	1580		1580

УВС АЙМАГ ХЯРГАС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 6 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 17

Дэлгэр баг

ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫН ТӨЛБӨР ХУРААМЖИЙГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 35.1.18 дахь заалтууд, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсгүүд, Захиргааны Ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дэх удаагийн сонгуулийн ээлжит 04 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын хэмжээнд мөрдөгдөх энгийн хог хаягдлын төлбөр хураамжийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Тогтоосон хураамжийг орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлж ажиллахыг сумын Засаг дарга (В.Сайнбилэг), татварын улсын байцаагч (Б.Хандхүү) нарт үүрэг болгосугай.

3.Тогтоолын бүрдлийг хангаж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын хууль, эрх зүйн мэргэжилтэн (Н.Бааст)-д даалгасугай.

4.Энэхүү тогтоолыг Хууль зүй, дотоод хэргийн яам эрх зүйн хэм хэмжээний актаар бүртгэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

5.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Я.Батмөнх)-д үүрэг болгосугай.

ДАРГА

С.БУЛГАНХҮҮ

*Хяргас сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн
17 дугаар тогтоолын хавсралт*

**СУМЫН ХЭМЖЭЭНД МӨРДӨГДӨХ ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫН
ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ**

Д/Д	Хог хаягдал гаргагч эх үүсвэрүүд		Хэмжих нэгж	Төлбөрийн хэмжээ (төгрөг)
1	2		3	4
1	Өрхийн иргэн бүр		Сар бүр	250
2	Төсвийн байгууллагууд		Сар бүр	5,000
3	Баяр наадам, нийтийг хамарсан үйл ажиллагааг зохион байгуулагч		Сар бүр	20,000
4	Шатахуун түгээх станц		Сар бүр	5,000
5	Банк		Сар бүр	2,500
6	Явуулын худалдаа	Иргэн	Сар бүр	5,000
		Аж ахуйн нэгж	Сар бүр	5,000
7	Үйлчилгээний газрууд	Цайны газар	Сар бүр	1,000
		Үсчин, гоо сайхан	Сар бүр	1,000
		Халуун ус	Сар бүр	1,000
		Мал эмнэлэг	Сар бүр	3,000
		Хүнс, барааны дэлгүүр (тусгай зөвшөөрөлтэй)	Сар бүр	5,000
		Хүнс, барааны дэлгүүр (тусгай зөвшөөрөлгүй)	Сар бүр	3,000
		Жижиг цех	Сар бүр	2,000
		Авто, дугуй засвар, гагнуур	Сар бүр	2,000
		Аялал, жуулчлалын бүсэд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллага, иргэн	Сар бүр	20,000
8	Үйлдвэрийн газрууд	Ноос, эсгийний цех	Сар бүр	5,000
		Блок, тоосгоны үйлдвэрлэл	Сар бүр	5,000
		Модон эдлэл, хөрөө араам	Сар бүр	2,000
		Уурын зуух	Сар бүр	30,000
		Малын гаралтай түүхий эдийн хог хаягдал	Сар бүр	50,000
9	Ашиглалтын зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж		Сар бүр	100,000
10	Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж		Сар бүр	50,000
11	Хээрийн түр анги, кемп, отог		Сар бүр	40,000

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 7465 дугаарт бүртгэв.

СҮХБААТАР АЙМГИЙН ЭРДЭНЭЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 8 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 08

Чоно гол

“БЭЛЧЭЭР АШИГЛАХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ”

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.13, 35.1.14, 48 дугаар зүйлийн 48.1, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.6 дах заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын ээлжит 5 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Бэлчээр ашиглах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Бэлчээр ашиглалтын гэрээг байгуулж, журмын хэрэгжилтийг ханган, үр дүнг жил бүр тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (Ч.Алдарбат)-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын Хөдөө аж ахуй, байгаль орчин уул уурхай хариуцсан хороонд үүрэг болгосугай.

ДАРГА

Н.АРИУНТУНГАЛАГ

*Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралын даргын
2025 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн ээлжит
V дугаар хуралдааны 08 дугаар тогтоолын хавсрлт*

БЭЛЧЭЭР АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг журам

1.1.Бэлчээрийг орон нутгийн бэлчээрийн экологийн чадавхад суурилсан аргачлалаар улирлын хуваарьтай төлөвлөх, бэлчээрийн даац, багтаамжид тохируулан малын тоо толгойн зохистой хэмжээг бий болгож, бэлчээр байгалийн жамаараа нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, зүй зохистой ашиглах, хамгаалахад нутгийн захиргаа, малчид, бэлчээр ашиглагчдын хооронд үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулахад оршино.

1.2.Бэлчээрийн төлөв байдал чанарыг хадгалах, хөрсний үржил шим буурах, бэлчээрийн ургамлын бүрхэвч талхлагдаж хөрс элэгдэх, эвдрэх, хуурайших, намагших, давсжих, бохирдохоос сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тодорхой хувийг бэлчээр ашиглагч малчин хариуцна.

1.3.Энэхүү журам нь Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Газрын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Иргэний хууль, Малын генетик нөөцийн тухай, Газрын төлбөрийн тухай хууль, Тариалангийн тухай хууль, Ойн тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжуудаар зохицуулагдана.

Хоёр. Бэлчээр ашиглалтыг төлөвлөх

2.1.Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд бэлчээрийг улирлаар ашиглах, зун-намрын бэлчээрийг сар, улирлаар сэлгэх, ашиглах, өнжөөх, хуваарь, отор нүүдэл хийх, худаг ус гаргах, засварлах, хадлангийн талбайг ашиглах, хамгаалах, сайжруулах, бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх, бэлчээрийг ашиглах, зохистой ашиглалтыг нэвтрүүлэх замаар доройтсон бэлчээрийг сайжруулах зэрэг арга хэмжээг тусгана.

2.1.1.Бэлчээр ашиглалтыг төлөвлөхдөө дараах зарчмыг баримтална;

2.1.2.Бэлчээрийн даац, багтаамж, экологийн чадавхад суурилах;

2.1.3.Бэлчээр ашиглагчдын тэгш оролцоог хангах;

2.2.Тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө /цаашид “Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө гэх/ нь дараах шаардлагыг хангасан байна.

2.2.1.Бэлчээрийн төлөв байдал чанарт хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний /фотомониторинг гэх/ дүнд үндэслэсэн байх;

2.2.2.Бэлчээрийг улирлаар ашиглах, сэлгэх, өнжөөх хуваарь гаргах;

2.2.3.Тариалангийн талбайгаас 500-1000 метрээс гадагш байх;

2.2.4.Бэлчээрийн ургац сайтай хэсгээс хадлан бэлтгэх, бэлчээр дэх уст цэг, хужир бүхий газрыг нийтээр ашиглах нөхцөлийг бүрдүүлэх;

2.2.5.Тухайн сумын нутаг дэвсгэрт бэлчээр ашиглагч болон төсөл хэрэгжүүлэгч нэгж, бэлчээр ашиглалтын жилийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхдээ баг, сумын Засаг даргатай хамтран ажиллана.

Гурав.Бэлчээрийн төлөв байдлыг хянах, даац тогтоох.

3.1.Бэлчээрийн төлөвлөлт, төлөвлөгөөний хэрэгжилт болон бэлчээр ашиглалтын үр нөлөөг фотомониторингийн үр дүнгээр 8-р сарын 15-ны дотор тогтоосон байна.

3.2.Бэлчээрийн төлөв байдлыг үнэлж, ургац тогтоохдоо улирлын бэлчээрийг төлөөлөхүйц мониторингийн цэг дээр тогтсон аргачлалыг баримтлан гүйцэтгэнэ.

3.3.Мониторингийн цэгийг сонгохдоо баг болон малчид зохион байгуулалтад орсон тохиолдолд хэсэг, бүлгийн улирлын бэлчээр болон бэлчээрийн нийтлэг хэв шинжийг төлөөлөх чадварыг нь харгалзан тогтоох ба энэ ажилд малчдын төлөөллийг оролцуулна.

3.4.Мониторингийн цэгийн байршлыг сумын Засаг даргын захирамжаар баталгаажуулж, сумын бэлчээр ашиглалтын зурагт нэг бүрчлэн тэмдэглэнэ.

3.5.Фотомониторингийн аргачлалын дагуу буулгасан зурган мэдээлэлд боловсруулалт хийж, төлөв байдлыг тодорхойлох, ургацын мэдээ гаргах ажлыг сумын газрын даамал гүйцэтгэнэ.

3.6.Бэлчээрийн ашиглалт, байршил, зааг өөрчлөгдсөн зэрэг шалтгаанаар цэгийг солих буюу шинээр нэмж болно.

3.7.Газрын даамал, Хөдөө аж ахуйн тасаг, Байгаль орчны хяналтын улсын байцаагч бэлчээрийн ургацын мэдээг хянаж, албан ёсны дүгнэлт гаргана.

3.8.Бэлчээрийн даацыг Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.7 дах хэсэгт заасны дагуу тогтоох.

Дөрөв.Бэлчээр ашиглалтын талаар сум, багийн нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

4.1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.1.Сумын тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг батлах, биелэлтийг хэлэлцэж чиглэл өгөх;

4.1.2.Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан нутаг дэвсгэртээ бэлчээрийн болон хагас суурин мал аж ахуй зэрэг бэлчээр ашиглагч бусад аж ахуйг хөгжүүлэхдээ бэлчээрийн экологийн чадавх, тохиромжтой болон хэрэгцээт байдлыг үндэслэн бүсчлэн тогтоох;

4.2.Багийн иргэдийн Нийтийн Хурал дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.2.1.Жил бүрийн 10-р сарын 01-ны дотор хуралдаж өмнөх жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, гэрээний хэрэгжилтийг хэлэлцэх;

4.2.2.Бэлчээр хамгаалах чиглэлээр ОНХС-ийн хөрөнгөөр тухайн жилд хийж гүйцэтгэх арга хэмжээний саналыг хэлэлцэж батлах;

4.2.3.Бэлчээрт усан хангамжийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзвэл саналыг сумын Засаг даргад уламжлах;

4.2.4.Бэлчээрийн төлөв байдлын өөрчлөлт, даацыг фотомониторингийн аргаар тодорхойлох, дараа жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах суурь болгоход малчдыг татан оролцуулах;

4.2.5.Бэлчээрийн хамгаалах чиглэлээр ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажлын зарцуулалтын байдалд хяналт тавих;

4.3.Сумын Засаг дарга дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.3.1.Газрын тухай хуулийн 52.2-т заасны дагуу тухайн жилийн бэлчээрийн чанар, бүтээмжийн фотомониторингийн дүн, багийн иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг тогтоох;

4.3.2.Сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;

4.3.3.Багийн Засаг даргын ажлыг үнэлэхдээ тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө болон энэ журмын хэрэгжилтийг нэг үзүүлэлт болгох;

4.3.4.Энэ журмын хүрээнд үлгэр жишээ ажиллаж буй хоршоо, малчны бүлэг, малчин өрхийг давуу эрхээр улсын төсөв болон орон нутгийн хөгжлийн сангаас хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх, төв, орон нутгийн төрийн байгууллагын шагналд тодорхойлох;

4.3.5.Гол горхи, булаг шандын эх ундаргыг хамгаалах, эрчимжсэн суурин мал аж ахуй эрхлэх болон тэжээвэр амьтныг өсгөн үржүүлэх, цөлжсөн бэлчээр хамгаалах, сайжруулахаас бусад тохиолдолд бэлчээр хашихыг хориглох арга хэмжээ авах;

4.3.6.Малчдад уламжлалт бэлчээр ашиглалт, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, сайжруулах талаар сургалт зохион байгуулах;

4.3.7.Бэлчээрийн хөнөөлт мэрэгчид, хортон шавьж устгах ажлыг малчдын оролцоотой зохион байгуулах;

4.3.8.Өвөлжөө, худаг уст цэгийн байршлыг шийдвэрлэх;

4.3.9."Малчин, малчны бүлэгтэй бэлчээр ашиглалтын гэрээ",Өөр аймаг сумын "Отрын малчдад бэлчээр ашиглуулах гэрээ"-г тус тус байгуулах;

4.4.Сумын газрын даамал дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.4.1.Сумын бэлчээрийн хэмжээ, байршлыг зураглан сумын газрын мэдээллийн санд бүртгэх;

4.4.2.Сумын Засаг даргын хоршоо, малчдын хэсэг, бүлэгтэй байгуулсан бэлчээр ашиглуулах гэрээг сумын газрын мэдээллийн нэгдсэн санд бүртгэх;

4.4.3.Бэлчээр ашиглуулах гэрээ боловсруулах, хэрэгжилтийг дүгнэх чиглэлээр холбогдох албан тушаалтан, байгууллага, малчдыг мэдээллээр хангах;

4.5.Багийн Засаг дарга дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.5.1.Багийн тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг малчдын оролцоотойгоор боловсруулж багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;

4.5.2.Энэ журамд заасан Бэлчээр хамгаалах чиглэлээр хөрөнгийг төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах;

4.5.3.Тухайн жилд Бэлчээр хамгаалах чиглэлээр ОНХС-д төвлөрсөн хөрөнгөөр багийн иргэдийн Нийтийн Хурлаас шийдвэрлэсэн ажлыг хэрэгжүүлэх, тайлагнах;

4.5.4.Сумын засаг даргын нутгийн Малчид болон отрын малчидтай байгуулсан "Бэлчээр ашиглалтын гэрээ"-ний хэрэгжилтийг хангах, "Бэлчээр ашиглалтын журам" зөрчсөн этгээдэд хугацаатай мэдэгдэх хуудас өгөх;

4.5.5.Өөр аймаг сумаас тус суманд (отор)-оор ирсэн Засаг даргаас зөвшөөрөл авч бэлчээр ашиглалтын гэрээ хэлцэл байгуулаагүй, мал эмнэлгийн үйлчилгээний бичиггүй отрын малчидтай нэн даруй уулзаж, шаардлага өгч, нүүлгэх ажлыг хийж гүйцэтгэх;

4.5.6.Малчин, мал бүхий иргэн өөрийн эзэмшлийн малын хашаа хороонд тэжээлийн ургамал тариалах;

4.5.7.Бэлчээрийн хөнөөлт мэрэгчид, хортон шавжтай тэмцэх ажлын хүрээнд тандалт судалгааг малчид болон малчдын бүлэгтэй хамтран хийж, сумын Хөдөө аж ахуйн тасаг болон нийтийг хамруулан

тэмцэх ажлыг зохион байгуулах;

4.5.8.Бэлчээрийг хуваарийн дагуу чөлөөлөөгүй этгээдийг албадан нүүлгэж, гарсан зардлыг төлүүлэх;

Тав. Бэлчээр ашиглагчдын эрх, үүрэг.

5.1.Сумын малчин, мал бүхий иргэд, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж нь бэлчээр ашиглалтын талаар дараах нийтлэг эрх, үүрэгтэй.

5.1.1.Бэлчээрийн даацад тохирсон малыг өсгөн үржүүлэх, ашиг шим сайтай үүлдрийн малаар сүргийг сэлбэх;

5.1.2.Багийн бэлчээр ашиглалтын жилийн төлөвлөгөө боловсруулах, бэлчээрийн даацыг фотомониторингийн аргаар тодорхойлох ажилд оролцох;

5.1.3.Бэлчээрийг өнжөөх, чөлөөлөх, сэлгэх, отор нүүдэл хийх талаар санал өгөх, гарсан шийдвэрийг дагаж мөрдөх;

5.1.4.Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд тусгасан бэлчээр ашиглалтын улирлын хуваарьт бэлчээрээс өөр бэлчээрт дур мэдэн нутаглахгүй байх, мөн бусдын өвөлжөөнд хашаа хороо дур мэдэн барихгүй, 2,5 км-ээс дотор нутаглахгүй байх, харьяа баг болон сайн дурын үндсэн дээр байгуулагдсан хэсэг, бүлгийн гишүүн малчид зөвшөөрсөн тохиолдолд барих;

5.1.5.Бэлчээр, усны эх үүсвэрийг хог хаягдал, хортой зүйлс, малын шавхай бууц, сэг зэмээр бохирдуулахгүй байх, нутаглаж байгаа газрынхаа хог хаягдлыг малчин, иргэн бүр өөрийн санаачилгаар хийж тухай бүр цэвэрлэж нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэх;

5.1.6.Бэлчээрийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал гаргах, уг арга хэмжээний явц, гүйцэтгэлд болон сангийн зарцуулалтын байдалд хяналт тавих;

5.1.7.Бэлчээр болон отрын бүс нутагт зөвшөөрөлгүй дур мэдэн цооног өрөмдөх, гүн өрмийн худаг гаргахгүй байх;

5.2.Өвөлжөө-хаваржаа, зуслан-намаржааны бэлчээр, отрын болон хадлангийн бүс нутагт хашаа хороо барих, өөр аймаг, сумын малыг дур мэдэн оруулах, худаг уст цэгийг дамжуулан ашиглуулах, түрээслүүлэх, худалдаалахгүй байх;

5.3.Бэлчээр, хашаа, саравч, бууц, усны эх үүсвэрийг бохирдуулахгүй, малын сэг зэм, хог хаягдлыг цэвэрлэж, хортон мэрэгчтэй тэмцэх, сумын Байгаль орчны байцаагч сумын мал эмнэлгээр ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэж, устгах.

5.4.Бэлчээрийн даацаас илүү гарсан малыг тухайн жилийн мал тооллого хүртэлх хугацаанд зах зээлд борлуулах, цөөн тооны мал бүхий малчин өрхөд хөлсөөр маллуулах, бэлчээрийн даац бүхий өөр аймаг, сумдын нутагт отроор явах санаачилга гаргах;

5.5.Бэлчээрийн газар ашигласны төлбөрийг холбогдох хууль, журмын дагуу төлөх.

Зургаа. Маргаан шийдвэрлэх хохирол нөхөн төлүүлэх

6.1.Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.2.Бэлчээрт учирсан хохирлыг нөхөн төлөх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Долоо. Журам хүчин төгөлдөр болох

7.1.Энэхүү журмыг Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т заасны дагуу захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр болно.

ТӨМӨР ЗАМЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 12 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар А/88

Улаанбаатар
хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2, Төмөр замын тээврийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.11, 11.2, 41.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.“Хөдлөх бүрэлдэхүүн ашиглах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигч байгууллагуудад даалгасугай.

3.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдлөх бүрэлдэхүүний газар (Б.Мөнхбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Б.АРТУР

*Төмөр замын газрын даргын 2025 оны
12 дугаар сарын 11-ний өдрийн
А/88 дугаар тушаалын хавсралт*

ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Монгол Улсын нутаг дэвсгэрт өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүйгээр төмөр замын тээвэрт хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглах, засварлах, техникийн үйлчилгээтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журмыг төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх), төмөр замын тээврийн байгууллага, хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигч дагаж мөрдөнө.

1.3. Энэхүү журмын нэр томъёог Төмөр замын тээврийн тухай хууль, төмөр замын тээврийн дүрэм, журам, үндэсний стандартад заасан утгаар ойлгож хэрэглэнэ.

1.4. Хөдлөх бүрэлдэхүүнд шинээр дугаар, гэрчилгээ олгох үйл ажиллагааг Монгол Улсын хилээр хөдлөх бүрэлдэхүүн нэвтрүүлэх бүртгэх, гэрчилгээ олгох журмаар зохицуулна.

Хоёр. Хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт

2.1. Төмөр замын тээврийн тухай хууль, төмөр замын тээврийн дүрэм, журам, үндэсний стандартын шаардлага хангасан хөдлөх бүрэлдэхүүнийг тээвэрлэлтэд ашиглана.

2.2. Хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигч нь өөрийн хөдлөх бүрэлдэхүүний техникийн бүрэн бүтэн байдал, засвар, техникийн үйлчилгээ, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хариуцна.

2.3. Тухайн төмөр замын тээврийн байгууллага нь ачаа хүрэх өртөө хүртэлх вагоны техникийн бүрэн бүтэн байдал, ашиглалтын хэвийн ажиллагааг хариуцна.

2.4. Хөдлөх бүрэлдэхүүний засвар, техникийн үйлчилгээ, ашиглалтын заавар, техникийн нормыг суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч боловсруулж, төрийн захиргааны байгууллага батална.

2.5. Дэвшилтэт технологитой хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт, засварын зааврыг суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч боловсруулж, төрийн захиргааны байгууллага батална.

2.6. Хөдлөх бүрэлдэхүүний улсын тооллогыг жил бүрийн 6 дугаар сарын 15-ны дотор суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч биет байдлаар зохион байгуулж, холбогдох тайланг төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

2.7.Хөдлөх бүрэлдэхүүнд үйлдвэрлэгчийн ашиглалтын заавар, стандартын дагуу засвар, техникийн үйлчилгээг хийнэ. Нэмэлт засвар, үйлчилгээ хийх шаардлагатай тохиолдолд төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж, энэхүү журмын 2.4-д заасан зааварт өөрчлөлт оруулсны үндсэн дээр хийнэ.

2.8.Ашиглалтын нормт хугацаа дууссан ачааны вагоныг тээвэрлэлтэд ашиглах тохиолдолд эрх бүхий байгууллагаар техникийн сорилт, оношилгоо хийлгэж, нөөцийг тогтоосны үндсэн дээр ашиглах эсэх шийдвэрийг төрийн захиргааны байгууллага нэг удаа гаргана. Ашиглах хугацаа нь вагоны үйлдвэрлэгчээс тогтоосон ашиглалтын хугацааны 30 хувиас ихгүй байна.

2.9.Осолд орсон хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдалд эрх бүхий техникийн хяналт оношилгоо, судалгааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн тээвэрлэлтэд ашиглах шийдвэрийг төрийн захиргааны байгууллага гаргана.

2.10.Ашиглалтын үед хөдлөх бүрэлдэхүүнд гэмтэл илэрсэн тохиолдолд төмөр замын тээврийн байгууллага нь хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигчид яаралтай мэдэгдэн, хойшлуулшгүй авсан арга хэмжээний талаар баримтжуулсан мэдээлэл хүргүүлнэ.

2.11.Ачааны вагоны өмчлөгч, эзэмшигч нь тээвэрлэлтийн үед өөрийн эзэмшлийн хөдлөх бүрэлдэхүүнд гарсан гэмтлийг засварлахад шаардагдах сэлбэгийг тухайн төмөр замын тээврийн байгууллагаас өгсөн жагсаалтын дагуу ханган нийлүүлнэ.

2.12.Төмөр замын тээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7-д заасны дагуу өмчийн хэлбэр харгалзахгүйгээр хөдлөх бүрэлдэхүүнийг улс орны нийгэм, эдийн засагт онцгой ач холбогдолтой тээвэрлэлтэд хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигчтэй зөвшилцсөний үндсэн дээр төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр ашиглаж болно.

2.13.Төрийн захиргааны байгууллага нь хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай байна.

2.14.Төмөр замын тээврийн мэдээлэл бүртгэх, солилцох журамд заасан маягтын дагуу холбогдох мэдээллийг хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигч байгууллага нь жил бүр төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

2.15.Хөдлөх бүрэлдэхүүний дугаарыг тэвшин дээр эрх бүхий засварын байгууллагаар стандартын дагуу хийлгэнэ.

2.16.Төмөр замын тээврийн хөдөлгөөний аюулгүй байдалд харшлагааргүй бол хөдлөх бүрэлдэхүүний тэвшин дээр өмчлөгчийн тусгай ялгах тэмдэг, лого тавьж болно.

2.17. Ачааны вагон өмчлөгч, эзэмшигч хуулийн этгээд нь 100 болон түүнээс дээш вагонтай бол орон тооны вагоны аж ахуйн мэргэжлийн инженертэй байна. 100 хүртэлх ачааны вагонтай бол техникийн зөвлөх үйлчилгээ эсвэл гэрээт ажилтан ажиллуулж болно.

2.18. Байршил тогтоох төхөөрөмж, техникийн үзүүлэлт мэдээлэл дамжуулах хэрэгслийг хөдлөх бүрэлдэхүүнд байрлуулах асуудлыг хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, өмчлөгч нь төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн шийдвэрлэнэ.

Гурав. Хөдлөх бүрэлдэхүүний засвар, техникийн үйлчилгээ

3.1. Хөдлөх бүрэлдэхүүний засвар, үйлчилгээг гэрээний үндсэн дээр тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд гүйцэтгэнэ.

3.2. Хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигч нь засвар, техникийн үйлчилгээний байгууллагыг сонгох эрхтэй.

3.3. Энэхүү журмын 3.1-т заасан этгээд нь засвар үйлчилгээндээ үндэсний стандарт заасан хугацаагаар чанарын баталгаа гаргана.

3.4. Энэхүү журмын 3.1-т заасан хуулийн этгээдээр засвар, техникийн үйлчилгээ хийлгэсэн, төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектын гэрчилгээтэй хөдлөх бүрэлдэхүүнийг төмөр замын тээвэрлэлтэд оролцуулна.

3.5. Засвар, техникийн үйлчилгээ хийсэн эрх бүхий байгууллага нь энэхүү журмын 2.13-т заасан мэдээллийн нэгдсэн санд хөдлөх бүрэлдэхүүнд хийсэн засварын мэдээллийг тухай бүр шинэчлэн оруулна.

3.6. Ашиглалтад байгаа вагоны үндэсний стандартад заасан засварын хугацаа дууссан тохиолдолд өөрийн гол дээрх ачааны нэгэн адил бичиг баримтаар засварт явахаас бусад тохиолдолд галт тэргэнд холбохгүй.

3.7. Вагоны дунд засварын хугацаа дууссан тохиолдолд төмөр замын тээвэрт ашиглахгүй ба зөвхөн төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд вагон хүрэлцээ дутах тохиолдолд хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигчийн хүсэлтээр эрх бүхий засварын байгууллагын техникийн дүгнэлтийг үндэслэн, засварын хугацааг ачааны вагонд 1 удаа 6 сар хүртэл, зорчигчийн вагонд 1 удаа 1 сар хүртэл хугацаагаар сунган, тээвэрлэлтэд ашиглаж болно.

3.8. Тусгай зөвшөөрөл бүхий ачааны вагоны засварын газар нь ирэх оны засварын төлөвлөгөөг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө ачааны вагон өмчлөгч, эзэмшигч нарын саналыг үндэслэн боловсруулж төрийн захиргааны байгууллага зөвшөөрснөөр батална.

3.9. Хөдлөх бүрэлдэхүүн засварлах эрх бүхий байгууллага, түүний салбар нэгж нь зөвшөөрөлтэй салбар замд засвар үйлчилгээг хийж гүйцэтгэнэ.

3.10.Хөдлөх бүрэлдэхүүний бүх төрлийн засварт зориулсан эд анги, сэлбэг материалыг үйлдвэрлэгчээс тогтоосон хугацаа, норм, техникийн үзлэгийн дүгнэлтийн дагуу ашиглаж, үечилсэн засварт оруулна.

3.11.Үечилсэн засварын үед шинэ болон сэргээн засварласан эд ангийг батлагдсан засварын зааврын дагуу тэдгээр эд ангиудыг туршилт сорилтод оруулж баталгаажуулалтын үндсэн дээр суурилуулж болох ба гэмтэлтэй цутгамал эд ангийг хөдлөх бүрэлдэхүүнд угсарахыг хориглоно.

3.12.Ээлжит үечилсэн засвар, үйлчилгээнд хамруулаагүй 1 жилээс дээш зогссон хөдлөх бүрэлдэхүүнийг тээвэрлэлтэд оролцуулах тохиолдолд эрх бүхий засварын байгууллагаар техникийн бүрэн үзлэгт хамруулж, шаардлагатай засвар үйлчилгээг хийсний дараа тээвэрлэлтэд оролцуулна.

3.13.Хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглалтаас хамааран тогтоосон үечлэлээс өөр хугацаанд засварлах тохиолдолд техникийн үндэслэл, тооцоо, судалгаа хийсний үндсэн дээр гүйцэтгэнэ.

3.14.Зүтгүүр, төмөр замаар явагч тусгай зориулалтын техник хэрэгслийн засвар үйлчилгээг үндэсний стандартад заагдсан хугацаа, засварын төрлийг баримтлан хийж гүйцэтгэнэ.

3.15.Их засвар хийхдээ засварын ажлын технологи, техникийн нөхцөл, ажлын даалгавар засвар үйлчилгээ хийх байгууллагын тусгай зөвшөөрөл, танилцуулгыг төрийн захиргааны байгууллагад урьдчилан ирүүлж зөвшөөрөл авна.

3.16.Зүтгүүр, машин механизм, зорчигчийн вагоны засварыг Монгол Улсын нутаг дэвсгэрт хийх боломжгүй тохиолдолд гадаад улсын засвар, техникийн үйлчилгээ хийх эрх бүхий этгээдээр хийлгэнэ.

ДӨРӨВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

4.1.Төрийн захиргааны байгууллага, төмөр замын тээврийн байгууллага болон хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигч тус тусын чиг үүргийн хүрээнд энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавина.

4.2.Энэхүү журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль эсхүл Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн 7467 дугаарт бүртгэв.

ТӨМӨР ЗАМЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 12 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар А/89

Улаанбаатар
хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, Төмөр замын тээврийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.13, 11.2, 46.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцаа, нөхцөл, сахилгын тусгай журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг төмөр замын тээврийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудад даалгасугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналтын газар (Ж.Болдхүү)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Б.АРТУР

*Төмөр замын газрын даргын
2025 оны 12 дугаар сарын 11-ний
А/89 дүгээр тушаалын хавсралт*

**ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨНТЭЙ ШУУД ХОЛБООТОЙ
АЖИЛТНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХАРИЛЦАА,
НӨХЦӨЛ, САХИЛГЫН ТУСГАЙ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Төмөр замын тээврийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, төмөр замын тээврийн дүрэм, журмыг хэрэгжүүлэх, олон улсын болон орон нутгийн тээвэрлэлтийн хэрэгцээг тогтвортой хангах, төмөр замын тээврийн тасралтгүй, хэвийн аюулгүй ажиллагааг хангахад, галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцаа, хөдөлмөрийн нөхцөл, сахилгын тусгай журмыг тогтоож мөрдүүлэхэд оршино.

1.2. Энэхүү журамд хэрэглэгдсэн нэр томьёо, тодорхойлолтыг Төмөр замын тээврийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Иргэний хууль, Зөрчлийн тухай хууль, тогтоомж, үндэсний стандартад заасан утгаар ойлгож хэрэглэнэ.

1.3. Энэхүү журмыг төмөр замын тээврийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг, галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтнууд дагаж мөрдөнө.

1.4. Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд бус холбоотой ажилтнуудын хөдөлмөр эрхлэлтийн харилцаа, нөхцлийг энэхүү журам болон холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

1.5. “Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтан (цаашид “ажилтан” гэх)” гэж энэхүү журмын хавсралтад заасан жишиг жагсаалтын дагуу төмөр замын тээврийн байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд шууд оролцдог, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх боломжтой галт тэрэгний хөдөлгөөнийг удирдах, зохицуулах, засвар үйлчилгээ хийх, хөдлөх бүрэлдэхүүнийг жолоодох, замын нөхцөл байдалд хяналт тавих, үйлчилгээний, хамгаалалтын зэрэг ажил эрхэлдэг өртөө, депо, замын, дохиолол холбоо, эрчим хүчний, зорчигч үйлчилгээний ажилтнуудыг хамруулан ойлгоно.

1.6. Төмөр замын тээврийн байгууллага нь хавсралтад заасан жишиг жагсаалтыг үндэслэж өөрийн үйлдвэрлэл үйлчилгээний онцлогоос шалтгаалан ажилтнуудын жагсаалтыг батална.

ХОЁР. ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨНТЭЙ ШУУД ХОЛБООТОЙ АЖИЛТНЫ ҮҮРЭГ

2.1.Ажилтан нь дараах нийтлэг үүргийг хүлээнэ:

2.1.1.олон улсын гэрээ, Төмөр замын тээврийн тухай хууль, төмөр замын тээврийн дүрэм, журмыг чанд биелүүлэх, техник хэрэгслийг дүрэм журам, технологийн горим, стандарт, нормын шаардлагын дагуу ашиглах, арчлах;

2.1.2.ачаа, тээш, ачаан тээшийг бүрэн бүтэн тээвэрлэх, үйлчлүүлэгчийн тээвэрлэлтийн эрэлт хэрэгцээ, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй, найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах;

2.1.3.зорчигч, үйлчлүүлэгч, төмөр замын тээвэртэй холбоотой үйл ажиллагаа явуулж буй этгээдээс төмөр замын тээврийн салбарт мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, үндэсний стандарт, нормативыг сахин биелүүлэхийг шаардах;

2.1.4.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрэм, журамд заасан шаардлагыг биелүүлэх.

2.2.Ажилтан нь энэхүү журмын 2.1-д заасан нийтлэг үүргээс гадна дор дурдсан үүргийг хүлээнэ:

2.2.1.холбогдох хууль, дүрэм, журмын дагуу зохих мэргэжлийн сургалтад хамрагдсан байх;

2.2.2.галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангаж, хөдөлгөөний зурмагийг чанд биелүүлэх;

2.2.3.хөдлөх бүрэлдэхүүнийг жолоодох болон хөдөлгөөний хэвийн ажиллагаа хангахтай холбогдсон дохио, сум, аппарат, хэрэгсэл, механизмыг технологийн горимын дагуу ашиглах;

2.2.4.хөдлөх бүрэлдэхүүний жолоодлогын бүхээг болон хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хангахтай холбогдсон дохио, сум, аппарат, хэрэгсэл, механизм, тоног төхөөрөмжийг удирдан ажиллуулдаг ажлын байранд эрх бүхий ажилтнаас бусад хүнийг нэвтрүүлэхгүй байх;

2.2.5.төмөр замын тээвэртэй холбоотой техник, технологийн мэдлэгээ сайжруулж, мэргэжлийн ур чадвараа нэмэгдүүлэх сургалтанд тогтмол хамрагдаж, техник ашиглалт, аюулгүй ажиллагааны арга барил эзэмшсэн байх;

2.2.6.төмөр замын тээврийн байгууллагын удирдлага, шууд харьяалах албан тушаалтан, ажлын ахлагч нарын албан үүргийн хүрээнд өгсөн тушаал, заавар, зааварчилгааг цаг тухайд нь бүрэн гүйцэд биелүүлэх, тухай бүр хариу илтгэж байх;

2.2.7.хариуцсан объектод байнга үзлэг, үйлчилгээ хийж хүний эрүүл мэнд, амь насанд аюул учирч болзошгүй нөхцөл бүрдсэн, байгууламж, төхөөрөмжид илэрсэн эвдрэл, гэмтэл, хэвийн бус ажиллагааны болон түүнд хүргэж болзошгүй нөхцөл байдлын талаар

тухай бүрд нь удирдах болон холбогдох ажилтанд шуурхай мэдэгдэж, үр дүнг илтгэх;

2.2.8.эрхэлсэн ажилтай нь холбогдуулан олгосон ажлын тусгай болон дүрэмт хувцас, бие хамгаалах болон дохионы хэрэгслийг төмөр замын тээврийн дүрэм, журамд зааснаар зориулалтын дагуу хэрэглэх;

2.2.9.ажил үүргээ гүйцэтгэж байхдаа төмөр замын тээврийн байгууллагаас баталж мөрдүүлж буй албан ярианы дэглэмийг баримталж ажиллах;

2.2.10.харилцагч байгууллага, иргэдийг тээвэрлэлт, ажил, үйлчилгээтэй холбогдолтой үнэн зөв мэдээллээр хангаж, шуурхай, соёлтой боловсон үйлчилж, ажил үйлчилгээний болон галт тэрэгний цагийн хуваарийг чанд баримтлах;

2.2.11.урьдчилсан болон хугацаат эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байх;

2.2.12.авлига, хээл хахууль, шан харамж авах, өгөх, өгөхийг шаардах, танил тал харах, үйлчлүүлэгчид тэгш бус хандаж, аль нэгэнд нь давуу эрх олгох зэрэг үйлдэл гаргахгүй байх;

2.2.13.хүний эрүүл мэнд, амь насанд аюул учирч болзошгүй саад тохиолдвол хөдөлгөөнийг зогсоох арга хэмжээ авах, байгууламж, төхөөрөмжид эвдрэл, гэмтэл илрүүлбэл тухайн осолтой газрыг хааж хамгаалах, засварлах арга хэмжээг яаралтай авч, мэдээлэх.

2.3.Ажилтныг шууд харьяалан удирдах албан тушаалтан нь дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ;

2.3.1.тушаал, шийдвэр, заавар, үүрэг даалгаврыг хуулийн хүрээнд тодорхой, ойлгомжтой өгөх, гүйцэтгэлийг бүрэн хангуулах, хянах, шалгах, шуурхай холбогдох арга хэмжээг авах, тайлагнах, мэдээлэх;

2.3.2.хууль бус үйл ажиллагаа илэрвэл цаг алдалгүй таслан зогсоож, байгууллага эсвэл нэгжийн удирдах албан тушаалтанд мэдэгдэж, өөрийн эрх, үүргийн хүрээнд холбогдох арга хэмжээ авах;

2.3.3.ээлж хүлээн авах, ажил хэвийн гүйцэтгэх нөхцөл бүрдээгүй үед ээлж хүлээлцэх шийдвэр гаргасан удирдах ажилтан нь түүнээс үүдэн гарах хариуцлагыг хүлээх;

2.3.4.ажлын байр эзэнгүй орхих, ажлын байранд унтах, бусадтай ажилтай холбогдолгүй яриа өрнүүлэх зэргээр ажил цалгардуулах, дутагдлыг нуун дарагдуулах, эвлэрэн хаацайлах зэрэг дутагдал гаргахгүй байх;

2.3.5.ажлын байранд ажил гүйцэтгэхэд саад болох техник хэрэгсэл, эд материал /зөвшөөрөгдсөнөөс бусад/ хадгалахгүй, мөн гадны хүн байлгахгүй байх.

ГУРАВ. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ

3.1.Олон улсын гэрээ, хэлэлцээр, Төмөр замын тээврийн тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хууль, стандарт тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан холбогдох эрх зүйн актад заасны дагуу дор дурдсан үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1.төмөр замын тээврийн тухай хууль, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, төмөр замын тээврийн дүрэм, журам, стандарт, хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт зэргийг ажилтанд танилцуулах, зааварчилгаа өгөх, мэргэжлийн сургалт явуулах, зохих мэргэжлийн сургалтанд хамрагдаж эрх авсан болон мэргэжлийн зэргийн үнэмлэхтэй иргэнийг ажиллуулах;

3.1.2.галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажил, үүргийг хавсрах, шилжүүлэн ажиллуулах, орлон гүйцэтгүүлэх тохиолдолд холбогдох дүрэм, журмын дагуу зохих мэргэжлийн сургалтанд хамрагдаж эрх авсан ажилтанг томилон ажиллуулах;

3.1.3.ажилд шинээр орох иргэн болон ажилтныг эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт оруулж, эрүүл мэндээр тэнцсэн ажилтанг ажиллуулах;

3.1.4.төмөр замын тээврийн байгууллага, салбар зам эзэмшигч нь ажилтанд техникийн сургалт явуулах, мэргэжлийг нь дээшлүүлэх, мөн давтан сургах, шалгалт авах ажлыг зохион байгуулах;

3.1.5.ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангахад зориулсан хөрөнгийг жил бүрийн төсөв, хамтын гэрээнд тусган зарцуулах, хамтын гэрээгүй бол хөдөлмөрийн дотоод журамд тусгаж хэрэгжүүлэх;

3.1.6.ажилтныг албан үүргээ биелүүлэхэд шаардагдах ажлын онцлогт тохирсон, хөдөлмөрлөх нөхцөлийг хангасан ажлын байр, техник хэрэгсэл, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтанд ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, хор саармагжуулах болон ариутган цэвэрлэх бодис, халуун хоол, хүнсээр хангах;

3.1.7.дотоод хяналт шалгалтыг тогтмол явуулах;

3.1.8.технологийн өөрчлөлт, осол, зөрчил гарсан шалтгааныг тогтоож, түүнийг арилгахаар авсан арга хэмжээг хамт олонд тухай бүр мэдээлж, давтан гарахаас урьдчилан сэргийлэх;

3.1.9.галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилд хоёроос дээш ажилтан ажиллаж байгаа нөхцөлд аль нэгийг нь ахлуулан ажиллуулах;

3.1.10.ажилтны ажлын байр нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын шаардлагад бүрэн нийцүүлсэн байх;

3.1.11.төмөр замын тээврийн тухай хуулийн 11.1.26-д заасан Эрүүл мэндийн үзлэг хийх журмын дагуу үзлэгт орж тэнцсэн, 18

насанд хүрсэн иргэнийг галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажил, албан тушаалд холбогдох хууль, журмын дагуу томилон ажиллуулах;

3.1.12.харьяалал болон өмчийн төрөл хэлбэрээс үл хамаарч хөдлөх бүрэлдэхүүн жолоодохтой холбоотой харилцааг Төмөр замын тээврийн тухай хуулийн 11.1.17-д заасан Хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрх олгох журмаар зохицуулах;

3.1.13.дадлагажигч ажилтныг галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны хяналт дор төмөр замын объектийг биечлэн ажиллуулах нөхцлийг хангах;

3.1.14.Төмөр замын тээврийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1-т заасны дагуу ажилтныг гэнэтийн ослын даатгалд заавал хамруулах;

3.1.15.ажилтныг шагнах урамшуулах.

3.2.Технологийн тасралтгүй ажиллагаатай байгууллагын ажилтны ээлж солилцоход дор дурдсан нөхцөлийг хангасан байна:

3.2.1.дараагийн ээлжинд хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, бүрэн хангуулах;

3.2.2.ажлын цаг дуусахаас өмнө тухайн ээлжинд гүйцэтгэсэн ажлын тоон болон чанарын үзүүлэлтийг шалгах;

3.2.3.ажилтан ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд түүнийг ажлаас түр чөлөөлж, өөр ажилтныг томилох болон шаардагдах бусад арга хэмжээг авах;

3.2.4.байгалийн гамшиг, осол, зөрчил гарсан эсхүл гарч болзошгүй нөхцөл бүрдсэн тохиолдолд ээлж хүлээлцэхийг түр хойшлуулж, тухайн ажлын байранд аюулгүй ажиллах нөхцөл бүрдсэний дараа ээлж солилцох;

3.2.5.ээлж солилцох, ажил хүлээлцэх үед хариуцсан хөдлөх бүрэлдэхүүн, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын багаж, хэрэгсэл болон бусад багаж хэрэгсэл бүрийг биечлэн үзэж хүлээлцэх;

3.2.6.ээлж хүлээлцэх тогтоосон нөхцөл бүрдээгүй үед ээлж хүлээн авсан бол түүнээс үүдэн гарах хариуцлагыг ээлж хүлээн авагч хариуцах.

ДӨРӨВ. АЖИЛТНЫ ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛ

4.1.Ажилтны ажиллах хөдөлмөрийн нөхцөл нь Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын шаардлагад нийцсэн байна.

4.2.Ажил олгогч, ажилтан нь Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай болон Төмөр замын тээврийн тухай хуульд заасан эрх, үүргийг эдэлнэ.

4.3.Төмөр замын тээврийн байгууллага нь галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажлын байранд хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээг хийлгэх, нөхцлийг сайжруулах, шинэ техник технологийг нэвтрүүлэх зардлыг жил бүр төсөвт тусган хэрэгжүүлнэ.

4.4.Уртын ээлжээр болон хүн ам төвлөрсөн хот суурингаас алслагдмал газарт байнгын ажлын байранд ажилладаг ажилтны нийгмийн асуудлыг Хамтын гэрээ, Хөдөлмөрийн дотоод журамд нэн тэргүүнд шийдвэрлэхээр тусган хэрэгжүүлнэ.

ТАВ. АЖИЛТНЫ АЖИЛ, АМРАЛТЫН ДЭГЛЭМ

5.1.Ажилтны ажил, амралтын дэглэм нь дараах үндсэн шаардлагыг хангасан байна:

5.1.1.хөдөлмөрийн болон хамтын гэрээнд заасан долоо хоногийн ажлын цаг, ердийн ажлын өдрийн үргэлжлэх цаг, ээлжийн ажлын хоногт үргэлжлэх хугацаа, ээлжийн ажлын эхлэх, дуусах цаг, завсарлага, амралтын өдөр нь Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжид нийцсэн байна;

5.1.2.тасралтгүй ажиллагаатай ажлын байранд ээлжийн хуваариар ажлын цаг нь зохицуулагддаг ажилтныг галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагт зохицуулан ажиллуулах ба ажлын цаг нь тухайн сард ажиллавал зохих ажлын цагаас ихгүй байна;

5.1.3.ээлжийн хуваариар ажилладаг ажилтны ажилласан цаг нь ажлын ачаалал, зурмагийн зохицуулалтаас хамааран тухайн сард ажиллавал зохих ажлын цагт хүрэхгүй тохиолдолд нэмэлт ажил, үүргийг гүйцэтгүүлж болох ба ажлын цагийг нь нэгтгэн бодно;

5.1.4.ажлын онцлогийг харгалзан тасралтгүй ажиллагаатай ажлын байранд ажилладаг ажилтныг 2-оос илүү шөнийн ээлжинд дараалуулан ажиллуулахгүй;

5.1.5.ажилтныг ээлжинд ажиллуулахдаа Хөдөлмөрийн тухай хуулийн 87 дүгээр зүйл, дуудлагаар ажиллуулах тохиолдолд 89 дүгээр зүйлийг дагаж мөрдөнө;

5.2.Ажлын цаг:

5.2.1.хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхүйц нөхцөл байдал, байгалийн давагдашгүй хүчин зүйл бий болсон, түүнийг сэргээн засварлах хүртэл хугацаанд ажилласан тохиолдолд амралтын дэглэмийг Хөдөлмөрийн дотоод журам эсхүл хамтын гэрээгээр зохицуулна.

5.2.2.ажилтны тасралтгүй ажиллах хугацаа нь 8 цагаас ихгүй байх бөгөөд хамтын болон хөдөлмөрийн гэрээнд тохиролцсон бол 4 хүртэл цагаар нэмэгдүүлж болно;

5.2.3.зүтгүүрийн бригадын ажлын цагийг ажилтантай тохиролцсоны үндсэн дээр ажил олгогч дараах хугацаагаар тогтоож өгнө:

5.2.3.1.ажилд бэлтгэх, зааварчилгаа авах, шалгалт өгөх хугацаа;

5.2.3.2.аяллын өмнөх болон дараах эмчийн үзлэгт хамрагдах хугацаа;

5.2.3.3.аяллын болон ажил гүйцэтгэсэн хугацаа;

5.2.3.4.ажил хүлээлцэх болон хүлээсэн хугацаа;

5.2.3.5.зүтгүүрийн бригад зорчигчоор аялах хугацаа болон хүлээсэн хугацаа;

5.2.3.6.сорил тавьсан хугацаа.

5.2.4.энэхүү журмын 5.2.3-т заасан нийт хугацаа 12 цагаас хэтрэхгүй байна.

5.2.5.зүтгүүрийн бригадыг дараалуулан хоёроос дээш удаа шөнийн цагаар ажиллуулахгүй. Энэ шаардлага нь эргэлтийн депо, амрах байрнаас буцаж байгаа болон зорчигчоор аялж байгаа зүтгүүрийн бригадад хамаарахгүй;

5.2.6.сэлгээний бригадыг ээлж солилцохоос 30 минутын өмнө өөр өртөөнд ажиллуулахаар явуулахгүй;

5.2.7.зүтгүүр, зорчигчийн галт тэрэгний бригадын цагийг үндсэн байрнаас эргэлтийн байр хүртэл явсан, эргэлтийн байрнаас үндсэн байранд хүрэлцэн ирсэн цагийн нийлбэрээс амрах нөхцөлөөр хангагдсан өртөөнд амарсан хугацаа, зорчигчийн вагонд амарч явсан хугацааг хасаж, үндсэн ба эргэлтийн өртөөнд ажилласан бэлтгэл, төгсгөлийн цагийг ажилтан тус бүр дээр нэмж тооцно;

5.2.8.галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн дагуу үндсэн ажлын байранд дуудагдан ирсэн зүтгүүрийн бригадын ажилтныг аялал хойшлогдсон тохиолдолд 3 цагаас багагүй хугацаагаар амрах нөхцөлөөр хангагдсан байранд амрааж дахин дуудаж болно;

5.2.9.зүтгүүрийн бригад нь зүтгүүр, галт тэргийг хүлээн авахаар зүтгүүрээр болон бусад тээврийн хэрэгслээр сулаар явсан хугацааг ажлын цагт тооцно;

5.2.10.зүтгүүрийн бригад болон тасралтгүй ажиллагаатай ажлын байранд ээлжийн хуваариар ажлын цаг нь зохицуулагддаг ажилтны шөнийн цагаар ажиллах цагийг бууруулахгүйгээр тогтооно. Зааварлагч машинчийн аялалд явж ажилласан цагийг дагалдан явсан тухайн галт тэрэгний машинчийн ажлын цагийн нэгэн адилаар тооцно;

5.2.11.тасралтгүй ажиллагаатай ажлын байранд ээлжийн хуваариар ажлын цаг нь зохицуулагддаг ажилтны ажил хүлээлцэх цаг 20 минутаас ихгүй байна. Ажлын онцлогоос шалтгаалан төмөр замын

тээврийн байгууллага ажил хүлээлцэх хугацааг тогтоож болно;

5.2.12.зорчигчийн галт тэрэгний дарга, тасалбарын явуулын нярав, тээш түгээгч, механик, засварчин болон тэдгээртэй адилтгах ажилтны ажлын цагийн хуваарийг зүтгүүрийн бригадын ажил, амралтын цагийн дэглэмтэй адилаар тогтоож болно;

5.2.13.зорчигчийн вагоны хоёр үйлчлэгчийн аяллын мөрөн дэх нийт ажиллах хугацааг тус бүрд тэнцүү хуваах ба зорчигчийн галт тэрэгний эргэлт, дамжин өнгөрөх цэгүүдэд ажиллах ээлжийн хуваарьтай байна;

5.2.14.тусгай үйлчилгээний болон албан хэрэгцээний вагоны үйлчлэгчийн ажлын цагийн хуваарийг батлагдсан ажил, амралтын дэглэмийг үндэслэн 1 талын ээлжинд 12 цагаас ихгүй байхаар зохицуулах бөгөөд аялалд явах цагийг галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг, суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагаар тогтооно;

5.2.15.сэргээн босгох галт тэрэгний бригад нь сургалт-бэлтгэлийн ажил гүйцэтгэх, мөн гэрээгээр ажил гүйцэтгэхээр бол ердийн хуваарийн үндсэн дээр ажлын цагийг тогтооно;

5.2.16.зам, засварын ажилчид ажил гүйцэтгэж буй хэсэглэл руу зорчихдоо галт тэрэг, авто машинаар зорчсон бол зурмагийн дагуу зорчсон цагийг оруулж тооцно;

5.2.17.дамжуулах галт тэрэг, сэлгээний болон түлхэгч зүтгүүр дээр тогтмол буюу түр хугацаагаар ажиллуулахаар зүтгүүр, галт тэрэгний бригадын ажилтныг байнгын оршин суудаг газраас явуулахад энэ журам хамаарахгүй.

5.3.Илүү цаг:

5.3.1.төмөр замын тээврийн хэвийн тасралтгүй үйл ажиллагаанд саад учруулсан байгалийн давагдашгүй хүчин зүйл, осол зөрчлийн хор уршиг эсвэл хэвийн үйл ажиллагаанд учирч болзошгүй саадыг арилгуулахаар ажилтныг илүү цагаар ажиллуулах тохиолдолд хамтын болон хөдөлмөрийн гэрээ, Хөдөлмөрийн дотоод журамд тодорхой тусгасан байна.

5.3.2.энэхүү журмын 5.4.1.д заасан цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулна. Амруулаагүй тохиолдолд Хөдөлмөрийн тухай хууль, хамтын гэрээнд заасны дагуу илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлсийг тооцож олгоно;

5.4.Ажлын цагийг сунгах тохиолдол:

5.4.1.зүтгүүр, галт тэрэгний бригадын тасралтгүй ажиллагааны үргэлжлэх хугацаа дууссан тохиолдолд бригадыг солих арга хэмжээг яаралтай авах, эсхүл төмөр замын тээврийн байгууллагын даргын шийдвэрээр хугацааг сунгана.

5.4.2.төмөр замын тээврийн хэвийн, тасралтгүй үйл ажиллагаанд саад учруулсан байгалийн гамшиг, сүйрэл, ослын хор уршгийг арилгах, эсвэл яаралтай хийхгүй бол хэвийн үйл ажиллагаанд учирч болзошгүй саадыг арилгах хойшлуулшгүй ажил гүйцэтгүүлэхээр галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтныг амралт эдэлж буйг үл харгалзан төмөр замын байгууллагын даргын шийдвэрээр ажилд дуудан оруулж болно;

5.4.3.энэхүү журмын 5.3.1-т зааснаас бусад тохиолдолд ажилтныг бүрэн амарч дуусаагүй байхад нь ажилд дуудахгүй.

5.5.Амралтын цаг:

5.5.1.ээлжийн хуваариар ажлын цаг нь зохицуулагддаг ажилтан долоо хоногийн амралтын хугацааг зурмагт 48 цагаас багагүй, 72 цагаас ихгүй байхаар тухайн сарын ажлын ээлжийн хуваарьт тэнцүү хуваарилж тусгах бөгөөд долоо хоногийн амралтын хугацаа нь тухайн сарын амралтын цагаас багагүй байна. Амрах хуваарийг урьдчилан мэдэгдсэн байна;

5.5.2.байгалийн гамшиг, сүйрэл, осол гарсан тохиолдолд төмөр замын тээврийн байгууллагын даргын шийдвэрээр долоо хоногийн амралтыг бууруулан 24 цагаар тогтоож болох ба дутууг дараа нь нөхөн амраана;

5.5.3.галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажлын байранд ажилтны хооллох завсарлагын хугацааг 30 минутаас багагүй, 2 цагаас ихгүй байхаар Хөдөлмөрийн дотоод журмаар тогтооно. Мөн байгаль, цаг уурын онцгой нөхцөл /хэт халалт, хүйтрэлт/-д гадаа ажилладаг ажилтны ажлын өдрийн завсарлагын хугацааг байгууллагын хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулж болно.

5.5.4.зүтгүүрийн болон галт тэрэгний бригадын ажилтны байнга оршин суудаг газарт олгох амралтыг тооцохдоо хоёр талын аялалд зарцуулсан нийт цагийг хэвийн амралт зохицуулах итгэлцүүрээр үржүүлж, гарсан үржвэрээс эргэлтийн байр буюу амрах нөхцөлөөр хангагдсан зорчигчийн вагонд амарсан хугацааг хасаж тооцно. Итгэлцүүрийг долоо хоногийн ажлын өдрийн дараах амралтын цагийн нийлбэрийг долоо хоногийн ажлын нормт цагт хувааж гаргана /80:40 = 2.0/;

5.5.5.ажлын өдрийн дараах хэвийн амралтын үргэлжлэх хугацааг 8 цагийн ажлын өдөртэй ажилтанд 16, 7 цагийн ажлын өдөртэй ажилтанд 17, 12 цагийн ээлжийн хуваариар ажилладаг ажилтанд 24 цагаар, уртын ээлжинд ажилладаг ажилтны амралтын үргэлжлэх хугацааг байгууллагын онцлогт тохируулан холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Хамтын гэрээ, Хөдөлмөрийн дотоод журамд

зааж тус тус тогтооно;

5.5.6.дараалсан хоёр ажлын өдрийн хоорондын тасралтгүй амралтын хугацаа 12 цагаас багагүй байна.

5.5.7.эргэлтийн болон солилцох байранд зүтгүүрийн бригадын аялал нэг талдаа 4 цагаас илүү үргэлжлэх тохиолдолд гүйцэтгэсэн ажлын цагийн хагасаас буюу 3 цагаас багагүй хугацаагаар амраах бөгөөд шөнийн цагаар /22-06 цаг/ ажилласан бол шөнийн цагаар ажилласан цагт ногдох хувиар нэмэгдэл амралт олгоно;

5.5.8.зүтгүүрийн бригадын ажилтныг эргэлтийн байр буюу ажил дууссан газарт нь зохих амралтыг нь эдлүүлэхгүйгээр буцааж болох боловч буцах замд нь ажиллуулж болохгүй;

5.5.9.зүтгүүрийн бригадын ажилтны ажлын цагийг халаа / турный/ ээлжээр зохион байгуулах тохиолдолд ажилтны байнга оршин суудаг газарт олгох амралтыг хоёр талын аялал хийсний дараа тооцож олгоно.

5.6.Сарын ээлжийн ажлын хуваарийг зохиохдоо галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн болон суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагтай зохицуулж, дараах зүйлийг удирдлага болгоно:

5.6.1.тасралтгүй ажиллагаатай ажлын байранд ээлжийн хуваариар ажилладаг ажилтан, мөн түүнчлэн ажлын цагийг хэсэглэн хуваах зохицуулалтаар ажилладаг ажилтны ажлын хуваарийг төмөр замын байгууллагын дарга баталж, өөрчилнө;

5.6.2.ажлын цагийг хэсэглэн хуваах зохицуулалтаар ажилладаг ажилтны ажлын хуваарийг үдийн хоолны завсарлагыг оролцуулан хоёроос илүүгүй завсарлагатай, завсарлага бүрийн үргэлжлэх хугацааг 1 цагаас багагүй, хоногийн туршид амралтын тасралтгүй үргэлжлэх хугацаа 12 цагаас багагүй байхаар тус тус зохионо;

5.6.3.төмөр замын байгууллага, салбар нэгжийн удирдлага нь ажилтны ажил, амралтын хуваарийг сар эхлэхээс 3 хоногийн өмнө ажилтанд танилцуулж, ажлын байранд ил тавьсан байна;

5.6.4.ажлын цагийн хуваарьт ажилтны ажил, амралтын цаг тодорхой заагдсан байх ба амарч байгаа ажилтанд хуваарийг танилцуулах, шийдвэр өгөх зэргээр захиргаанаас үүрэг хүлээлгэхгүй байна.

5.7.Уртын ээлжээр ажиллуулах:

5.7.1.Хөдөлмөрийн тухай хуулийн 92.1-д заасан горимоор үйл ажиллагаа явуулж байгаа ажил олгогчид үйлчилгээ үзүүлж байгаа төмөр замын тээврийн байгууллага нь тухайн байршилд уг горимыг хэрэглэж болно.

5.7.2.уртын ээлжээр ажиллах ажилтны ажлын өдрийн үргэлжлэл 12 цагаас илүүгүй байх бөгөөд Хөдөлмөрийн тухай хуулийн 87 дугаар зүйлийг баримтлан, мөн хуулийн 109.1-д заасны дагуу илүү цагийг тооцож нэмэгдэл хөлс олгоно.

5.7.3.уртын ээлжээр ажиллах ажилтны нэг ээлжид ажил үүрэг гүйцэтгэх хугацаа 14 хоног, амрах хугацаа 14 хоног байна. Байгууллагын онцлогт тохируулан энэ хугацааг өөрөөр тогтоож болно. Ингэхдээ Хамтын гэрээ, Хөдөлмөрийн дотоод журамд тодорхой зааж өгнө.

5.7.4.Хөдөлмөрийн тухай хуулийн 92.4-т заасан хугацааг багасгах тохиолдолд ажил үүрэг гүйцэтгэх, амрах хугацаа нь тэнцүү байхаар ажил олгогч, ажилтны төлөөлөгч харилцан тохиролцож болно.

5.7.5.уртын ээлжэхлэх болон дуусахад ажил олгогч хөдөлмөрийн дотоод журмаар тогтоосон байршил бүхий газраас ажилтныг ажлын байранд хүргэх, буцаах хугацааг ажилласан цагт тооцох бөгөөд энэ хугацаанд ажил олгогчоос хамаарахгүй шалтгаанаар саатсан хугацааг оруулахгүй.

5.7.6.уртын ээлжээр ажиллах ажилтны Хөдөлмөрийн тухай хуулийн 92.6-д заасан байршил бүхий газраас ажилдаа ирэх, буцах зардлыг ажил олгогч хариуцна.

5.7.7.уртын ээлжээр ажиллах ажилтны ажил, амралтын цагийн горим, уртын ээлжээр ажилласны нэмэгдэл зэргийг Хамтын гэрээ, Хөдөлмөрийн дотоод журамаар тогтоож болно.

5.7.8.Хөдөлмөрийн тухай хуулийн 92.10-д заасныг баримтална.

5.7.9.ажилтны сахилга, ажлын цагийн хуваарь, хөдөлмөрийн нөхцөл нь энэхүү журмын 5 дугаар бүлэг, мөн MNS 5080:2001 “Хөдөлмөрийн нөхцөлийн ангилал, хүчин зүйл, үнэлгээ” стандартын шаардлагыг бүрэн хангасан байна.

ЗУРГАА. САХИЛГЫН ШИЙТГЭЛ

6.1.Энэхүү журмыг зөрчсөн, сахилгын зөрчил гаргасан төмөр замын тээврийн байгууллагын ажилтанд Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2-т заасан шийтгэл ногдуулна.

6.2.Ажилтанд түүний буруутай байдлаас шалтгаалан Хөдөлмөрийн тухай хуулийн 123.2.1, 123.2.2-т заасан сануулах сахилгын шийтгэлийг дор дурдсан тохиолдолд ногдуулна:

6.2.1.албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заагдсан үүрэг, удирдлагаас өгсөн даалгавар, заавар биелүүлээгүйгээс төмөр замын объект, үйл ажиллагаанд саад учирсан, ачаа тээврийн зөрчил, гэмтэл гарах нөхцөл бүрдүүлсэн;

6.2.2.ёс зүйн зөрчил гаргасан нь нотлогдсон.

6.3.Хөдөлмөрийн тухай хуулийн 123.2.3-т заасан шийтгэлийг дор дурдсан тохиолдолд ногдуулна:

6.3.1.төмөр замын тээврийн осол, зөрчил гаргасан, гарах нөхцөл бүрдүүлсэн.

6.4.Хөдөлмөрийн тухай хуулийн 123.2.4-т заасан шийтгэлийг 1 жил хүртэл хугацаагаар хөдөлгөөнтэй шууд холбоотой бус ажилд шилжүүлэх байдлаар дор дурдсан тохиолдолд ногдуулан хэрэглэж болно.

6.4.1.хөдлөх бүрэлдэхүүн жолоодохдоо технологийн алдаа гаргаж осол, зөрчил гаргасан;

6.4.2.галт тэрэг хүлээн авах, явуулах, сэлгээний ажил гүйцэтгэхдээ технологийн алдаа гаргаж осол, зөрчил гаргасан;

6.4.3.зам засварын ажил хийгдэж буй газарт зохих ёсоор хамгаалалт хийгээгүйгээс хүн гэмтсэн, осол, зөрчил гарсан;

6.4.4.хариуцсан үүргээ биелүүлээгүйгээс хөдлөх бүрэлдэхүүнийг бусад тээврийн хэрэгсэлтэй мөргөлдүүлсэн;

6.4.5.дохиолол, төвлөрүүлэлт ба холбооны тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний технологийн алдаа гаргаж осол, зөрчил гаргасан;

6.4.6.вагон чингэлгийн ачааг бэхлэх, байршуулах техникийн нөхцөл зөрчиж осол, зөрчил гаргасан;

6.4.7.шуудан, тээш, зорчигчийн вагоны үйлчлэгч нь хаалгаа түгжээгүй, гүүшингийн халалтад хяналт тавих төхөөрөмжийн ажиллагааг тогтмол шалгаагүйгээс болж хүн гэмтсэн, осол гарсан;

6.4.8.зорчигчийн галт тэрэгний дарга, ажилтан эрх мэдлээ ашиглаж байгууллагад хохирол учруулсан.

6.4.9.галын аюулгүй байдлын холбогдох дүрэм зөрчсөнөөс хөдлөх бүрэлдэхүүнд гал гарсан;

6.4.10.аюултай бүсийн дэглэмийг хэрэгжүүлээгүйгээс хүний амь эрсэдсэн, гэмтсэн.

6.5.Хөдөлмөрийн тухай хуулийн 123.2.5-д заасан шийтгэлийг дараах сахилгын зөрчил гаргасан ажилтанд ногдуулна:

6.5.1.төмөр замын тээврийн осол гаргасан, гарах нөхцөл бүрдүүлсэн болон хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан;

6.5.2.ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн, ажилдаа согтуу буюу мансууран ирсэн;

6.5.3.төмөр замын объект, сэлбэг, хэрэгсэл, эд анги, бусад материалыг хулгайлсан, тоносон, үрэгдүүлсэн нь нотлогдсон;

6.5.4.хөдлөх бүрэлдэхүүний эд ангийг санаатайгаар задалсан, сулласан, эвдсэн, хөдлөх бүрэлдэхүүнд хориотой зүйлс нуусан;

6.5.5.албан тушаалаа ашиглан ачаа, тээш, ачаан тээш, зорчигчийг үнэ, хөлсгүй тээвэрлэсэн;

6.5.6.хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр дараалсан ажлын 3 өдөр ажил тасалсан, сардаа нийлбэр дүнгээрээ 4 ба түүнээс дээш өдөр

ажил тасалсан;

6.5.7.улсын хилээр хууль бусаар эд зүйлийг нэвтрүүлэх зорилгоор төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг нуувч болгон ашигласан.

6.6.Ажил олгогч нь сахилгын шийтгэлийг ногдуулахаасаа өмнө тухайн ажилтнаас бичгээр тайлбар, тодорхойлолт, хүсэлтийг хүлээн авч зөрчлийн шалтгааныг олон талаас судалж, үнэн зөвийг бодитоор дүгнэнэ.

6.7.Ажилтанд хөдөлгөөнтэй шууд бус холбоотой ажилд томилох сахилгын хариуцлага ногдуулсан тохиолдолд ажилтантай зөвшилцөж, шийдвэрлэнэ.

6.8.Хөдөлмөрийн тухай хуулийн 123.2.4-т заасан сахилгын шийтгэл хүлээсэн ажилтныг шийтгэлийн хугацаа дууссаны дараа холбогдох дүрэм, журмын дагуу шалгалт өгч, тэнцсэн тохиолдолд хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилд томилж болно.

6.9.Сахилгын шийтгэлийн талаарх гомдлоо ажилтан хууль тогтоомжид заасны дагуу шүүхэд гаргаж болно.

ДОЛОО. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

7.1.Энэхүү журмын хэрэгжилтэд Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, төмөр замын тээврийн байгууллагууд болон тэдгээрийн дотоод хяналтын нэгж, салбар, нэгжийн удирдлага хяналт тавина.

7.2.Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хууль эсхүл Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

*Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой
ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцаа,
нөхцөл, сахилгын тусгай журмын хавсралт*

**ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨНТЭЙ ШУУД ХОЛБООТОЙ АЛБАН
ТУШААЛЫН ЖИШИГ ЖАГСААЛТ**

- 1.Өртөөний дарга, ерөнхий инженер, орлогч дарга, инженер,техникч;
- 2.Өртөөний жижүүр, жижүүрийн оператор, туслах жижүүр;
- 3.Диспетчер, довын жижүүр;
- 4.Зөрлөгийн дарга, жижүүр;
- 5.Техникийн болон товарын конторийн оператор, вагон бичигч;
- 6.Галт тэрэгний найруулагч, туслах найруулагч, ивүүрчин;
- 7.Ачаа вагон хүлээлцэгч, агент, хүлээн авах пүүлэгч;
- 8.Галт тэрэгний хөдөлгөөний диспетчер;
- 9.Хөдлөх бүрэлдэхүүний машинч, туслах машинч;
- 10.Засварчин;
- 11.Вагон, чингэлгийн засвар, үйлчилгээний оператор;
- 12.Хөдлөх бүрэлдэхүүний засварын газрын дарга, мастер, механикч, засварчин;
- 13.Вагон үзэгч (ахлах), вагон үзэгч засварчин;
- 14.Дохиочин;
- 15.Сумчин, сум цэвэрлэгч;
- 16.Сэргээн босгох болон усны галт тэрэгний мастер
- 17.Зорчигчийн галт тэрэгний дарга, мастер;
- 18.Зорчигчийн болон тусгай зориулалтын вагоны үйлчлэгч;
- 19.Төмөр замын тээврийн аюулгүй байдал хариуцсан хяналтын байцаагч;
- 20.Хөргүүрт вагоны мастер;
- 21.Замын дээд, доод бүтцийн засвар, арчилгаа болон хяналтын бригадын дарга;
- 22.Зам барилга, засварын машин механизмын инженер-механикч, машинч;
- 23.Замын ахлах мастер, мастер;
- 24.Гүүрийн мастер;
- 25.Хянах, хэмжих вагон /сэв шалгагч, зам, хэмжигч/-ын тохируулагч;
- 26.Зам хэмжүүрийн оператор, тууз орчуулагч;
- 27.Сэв шалгагч, тэргэнцэрийн оператор;
- 28.Зам засварын чанарын хүлээн авагч;

- 29. Гармын жижүүр;
- 30. Замчин;
- 31. Тор засагч;
- 32. Дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, ба холбооны байгууламж, радио холбооны тоног төхөөрөмжийн засварчин, монтёр;
- 33. Дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламж хариуцсан механикч;
- 34. Зааварлагч машинч;
- 35. Авто тоормосын зааварлагч, машинч;
- 36. Зам төмөр шавагч;
- 37. Зам төмрийн гагнуурчин;
- 38. Дохиолол холбооны байгууламж хариуцсан инженер (дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбоо, радио холбоо, хажуугийн илрүүлэх систем);
- 39. Радио холбооны байгууламж хариуцсан механикч;
- 40. Галт тэрэгний хажуугийн илрүүлэх системийн механикч;
- 41. Зүтгүүрийн ээлжийн жижүүр-машинч.

БОЛОВСРОЛЫН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 11 дүгээр
сарын 28-ны өдөр

ДугаарА/563

Улаанбаатар
хот

“СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ТАВИХ ШААРДЛАГА, СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗАГВАР” БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.12 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн “Үзэл баримтлал батлах тухай” 176 дугаар тогтоолын хавсралтын 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрт тавих шаардлагыг нэгдүгээр, сургалтын хөтөлбөрийн загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрт тавих шаардлага, сургалтын хөтөлбөрийн загварын дагуу 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн үе шаттайгаар сургалтын хөтөлбөрийг боловсруулан баталгаажуулж, 2026-2027 оны хичээлийн жилээс эхлэн мөрдөж ажиллахыг мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн захирал нарт үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Дээд, мэргэжлийн боловсролын бодлого зохицуулалтын газар (Н.Нарангэрэл), хэрэгжилтэд арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир), сургалтын хөтөлбөрт агуулгын судалгаа хийх, сайжруулах, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн (П.Оюунаа)-т тус тус даалгасугай.

4.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Хөдөлмөрийн сайдын 2015 оны “Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн загвар батлах тухай” А/197, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны “Техникийн боловсрол, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн загвар, шаардлага батлах тухай” А/134, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны “Мэргэжлийн боловсрол олгох сургалтын төлөвлөгөөний загвар батлах тухай” А/159 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болгох ажлыг зохион байгуулж ажиллахыг Дээд, мэргэжлийн

боловсролын бодлого зохицуулалтын газар (Н.Нарангэрэл)-т даалгасугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Л.Төгсбаяр)-т даалгасугай.

САЙД

П.НАРАНБАЯР

*Боловсролын сайдын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны
өдрийн А/563 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

**СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ТАВИХ ШААРДЛАГА, СУРГАЛТЫН
ХӨТӨЛБӨРИЙН ЗАГВАР**

НЭГ. НИЙТЛЭГ ШААРДЛАГА

1.1.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын хөтөлбөр болон ажлын байран дахь сургалт, хосмог сургалтын хэлбэрээр явагдах хөтөлбөрийг төлөвлөн боловсруулах, батлан хэрэгжүүлэх, хянан сайжруулахтай холбоотой үүсэх харилцаанд энэхүү шаардлага, загварыг баримтлана.

1.2.Сургалтын хөтөлбөр нь Боловсролын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.13 дахь заалтад дурдсан цогц баримт бичиг бөгөөд сургалтын төлөвлөгөө нь хөтөлбөрийн салшгүй хэсэг болно. Сургалтын төлөвлөгөөг сургалтын хугацаа болон агуулга, цагийн харьцаа өөрчлөгдсөн тохиолдол бүрт шинэчлэн батална.

1.3.Сургалтын хөтөлбөр хөгжлийн тэргүүлэх чиглэл, бүс орон нутгийн онцлог, хөдөлмөрийн зах зээл, ур чадварын эрэлт, хэрэгцээ шаардлагыг хангасан, ажил олгогч, нийгмийн түншлэлийн оролцоонд тулгуурласан, мэдээллийн технологийн дэвшлийг тусгаж, ажил мэргэжлийн стандартад нийцсэн байна.

1.4.Боловсролын түвшинд тохирсон сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрмийн 3.4.9-д заасны дагуу энэхүү шаардлага загварт нийцүүлэн оролцогч талуудын оролцоотойгоор боловсруулж, сургалтын байгууллагын захирал батална.

1.5.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын хөтөлбөр, хамаарах чадамжийн нэгжийг мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийн тохирох түвшинд нийцүүлнэ.

1.6.Хөтөлбөрийн агуулгыг багц цагаар хэмжих бөгөөд сургалтын хөтөлбөрт залгамж холбоог уялдуулсан байвал зохино.

1.7.Сургалтын хэлбэрээс үл хамааран энэхүү сургалтын хөтөлбөрт тавих шаардлага, сургалтын хөтөлбөрийн загварыг мөрдөнө. Мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрийн агуулгын 30% нь онол, 70% нь дадлага, техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийн 40% нь онол, 60% нь дадлага байх ба онол, дадлагын харьцаанд (+/-5) хувийн өөрчлөлтийг хүлээн зөвшөөрнө.

1.8.Сургалтын байгууллага болон ажлын байран дахь, хосмог, зайны болон цахим сургалтын хэлбэрээр сургалтыг зохион байгуулахдаа суралцагчийн ялгаатай хэрэгцээ, ур чадварын түвшинг

харгалзан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тохируулга хийх буюу ганцаарчилсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж ашиглаж болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

1.9.Сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь, мэргэжлийн суурь хэсэгт мэргэжлийн онцлогоос хамаарч агуулгын интеграци хийх ба Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 11.4 дэх заалтыг баримтлана.

1.10.Сургалтын хөтөлбөр нь нийгмийн хөгжил, эдийн засгийн бүтээмжийг дэмжих, мэргэшлийн түвшин ахиулах, хос мэргэжил эзэмших боломжийг бүрдүүлэх, тасралтгүй хөгжих хэрэгцээг хангахад чиглэсэн байна.

1.11.Сургалтын хөтөлбөрт Боловсролын ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 6.4-д заасан агуулгыг тусгахаас гадна авлигын эсрэг, жендэрийн эрх тэгш байдал, боловсролын дижитал болон цахим шилжилт, ногоон ур чадвар олгох, насан туршын суралцахуйн эрхийн тогтолцоо, түүнийг дэмжих агуулгыг заавал тусгана.

1.12.Гадаад улстай хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тухайн улсын хэл дээрх болон албан ёсны баталгаажсан Монгол орчуулгын хамт сургалтын байгууллагын удирдлагууд хамтран баталсан байна.

1.13.Мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг мэргэшлийн үндэсний шаталсан бүтэцтэй нийцүүлэн чадамжийн нэгжийн агуулгаар боловсруулна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг Боловсролын ерөнхий газар хариуцна.

1.14.Сургалтын хөтөлбөрт тавих шаардлага, сургалтын хөтөлбөрийн загварын бүтцийн дагуу дараах байдлаар хэсэгчлэн тодорхойлсон болно. Үүнд:

1.14.1.Сургалтын хөтөлбөр;

1.14.2.Чадамжийн нэгжийн агуулга.

ХОЁР. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН БҮТЭЦ

2.1.Хөтөлбөрийн танилцуулга: Мэргэжлийн чиглэл, индекс, мэргэшлийн нэр, мэргэшлийн түвшин, суралцах хугацаа, мэргэшүүлэх чиглэл, хөтөлбөрийг боловсруулсан, зөвлөсөн, хянасан, дүгнэлт гаргасан багийн мэдээлэл, товчилсон үгийн тайлбар, агуулга байна.

2.2.Сайжруулсан тэмдэглэл: Хөтөлбөрийн хувилбарыг тодорхойлохдоо сайжруулалт хийсэн үндэслэл, өөрчлөлтийн талаарх товч тайлбар.

2.3.Сургалтын хөтөлбөрийн үндэслэл: Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээ, бүс, орон нутгийн хөгжлийн бодлого, ажил олгогчийн шаардлага, дотоод болон гадаадын ижил төстэй хөтөлбөрийн жишиг, харьцуулсан судалгаа, төгсөгчийн ажлын байранд шаардагдах үр чадвар эзэмшсэн байдал зэрэг холбогдох судалгааны үр дүнд суурилан сургалтын хөтөлбөрийн үндэслэлийг тодорхойлно.

2.4.Сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт: Хөтөлбөрийн зорилго, зорилтыг тухайн хөтөлбөрөөр төгсөгч мэргэжлээрээ 4-5 жил ажилласны дараа түүний мэдлэг, чадвар, хандлага төлөвшил ямар түвшинд хүрсэн байхыг төсөөлсөн ерөнхий үр дүн байдлаар хөтөлбөрийн оролцогч талууд (багш, суралцагч, төгсөгч, ажил олгогч, мэргэжлийн холбоод гэх мэт)-тай хамтран тодорхойлно. Хөтөлбөрийн зорилго, зорилтыг мэргэжлийн сургалт, мэргэжлийн боловсрол, техникийн боловсролын түвшинд шатлан гүнзгийрсэн, хэмжигдэхүйц байдлаар залгамж холбоотойгоор боловсруулсан байна.

2.5.Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн: Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг мэргэжлийн сургалт, мэргэжлийн боловсрол, техникийн боловсролын түвшинд шатлан гүнзгийрсэн, хэмжигдэхүйц байдлаар, төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, чадвар, хандлагыг Блюмын таксономи (Bloom's taxonomy) ашиглан түвшинд ангилан боловсруулж, олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллагын шалгуур шаардлага, Мэргэшлийн Үндэсний Шаталсан Бүтцийн түвшин тодорхойлогч, тухайн хөтөлбөрийн чиглэлийн мэргэжлийн холбоодоос тавьдаг нэмэлт шалгуур шаардлага болон хөтөлбөрийн зорилго, зорилттой тус тус уялдуулан тодорхойлсон байна.

2.6.Элсэгчдэд тавигдах шаардлага: Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд элсэгчдэд тавих шаардлагыг бичнэ.

2.7.Сургалтын хөтөлбөрийн агуулга: Энэ хэсэг нь дараах бүтэцтэй.

2.7.1.Чадамжийн нэгжийн жагсаалт, код;

2.7.2.Хөтөлбөрт хамаарах чадамжийн нэгжийг багцлах дүрэм;

2.7.3.Хичээлийн агуулгын уялдааг харуулсан зураглал.

2.8.Сургалтын төлөвлөгөө: Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой батлагдсан сургалтын төлөвлөгөө.

ГУРАВ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АГУУЛГЫГ ТОДОРХОЙЛОХ УДИРДАМЖ

3.1.Чадамжийн нэгж: Чадамжийн нэгжийг сонгохдоо ажил мэргэжлийн дүн шинжилгээ, ажил мэргэжлийн стандартад үндэслэнэ. Чадамжийн нэгжийн кодыг кодлохдоо мэргэжлийн чиглэл, индекс, мэргэшлийн нэр, мэргэшлийн түвшин, чадамжийн нэгжийн дараалал, хувилбарыг илэрхийлсэн байдлаар тодорхойлон, чадамжийн нэгжийн агуулгыг багц цагаар тооцож илэрхийлнэ. Мэргэжлийн болон техникийн

боловсролын сургалтын хөтөлбөр нь Мэргэжлийн болон Техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6.9-д заасны дагуу ерөнхий болон мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хэсгийн чадамжийн нэгж (хичээл)-ээс бүрдэнэ. Хэсэг тус бүр заавал болон сонгон судлах чадамжийн нэгжүүдтэй байна.

3.1.1.Ерөнхий суурь хэсгийн агуулга нь суралцагч мэргэшил, боловсрол эзэмшихэд шаардлагатай шинжлэх ухаан, техникийн, суурь мэдлэг олгох;

3.1.2.Мэргэжлийн суурь хэсгийн агуулга нь суралцагч мэргэшил, ур чадвар эзэмшихэд зайлшгүй шаардлагатай техникийн суурь мэдлэг, чадвар олгох;

3.1.3.Мэргэшүүлэх хэсгийн агуулга нь суралцагч мэргэжлийн үйл ажиллагааны чадвар, дадал эзэмшүүлэх, тухайн мэргэшлийг сонгон эзэмших.

3.2.Сургалтын төлөвлөгөө: Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын хичээлийн жилийн эхлэх, дуусах, үргэлжлэх хугацаа, зохион байгуулалтыг сургалтын төлөвлөгөөгөөр зохицуулах бөгөөд тухайн салбар, мэргэжлийн онцлог, байгалийн давагдашгүй хүчин зүйл, гамшиг, онцгой үеэс хамаарч уян хатан зохицуулалт хийж болно. Үйлдвэрлэлийн дадлагыг мэргэшлийн онцлогоос хамааран хөтөлбөрийн агуулгыг алдагдуулахгүйгээр дадлагын хугацаанд зохицуулалт хийж болно. Сургалтын хөтөлбөрийн үргэлжлэх хугацааг суралцагчийн нэг долоо хоногийн ачаалал 40 цагаас ихгүй байхаар төлөвлөх бөгөөд дараах ерөнхий зарчмыг баримтална.

3.2.1.Мэргэжлийн боловсролын 3 жилийн сургалт 6 улирлаас, 1 жилийн сургалт 2 улирлаас бүрдэх ба нэг улирлын үргэлжлэх хугацаа 18 долоо хоногоос ихгүй байна. Мэргэжлийн боловсролын 3 жилийн сургалтын төлөвлөгөө бүрэн дунд боловсрол болон мэргэжлийн боловсролын агуулгаас бүрдэнэ. Бүрэн дунд боловсролын агуулгад “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал (2024-2036)”-д тусгасан судлагдахууны агуулгын 60-аас багагүй хувийг элсэлтийн ерөнхий шалгалттай уялдуулан сургалтын төлөвлөгөөнд тусгана;

3.2.2.Техникийн боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд суралцагч шатлан суралцах нөхцөлийг бүрдүүлсэн байвал зохино. Техникийн боловсролын сургалтын улирлын үргэлжлэх хугацаа 16 долоо хоногоос багагүй байна. Боловсролын ерөнхий хуулийн 14.4-т заасан агуулгыг сургалтын хөтөлбөрт чадамжийн нэгж (хичээл)-ээр эсвэл холбогдох чадамжийн нэгж (хичээл)-ийн агуулгад тусган эзэмшүүлэхээр боловсруулна. Сургалтын төлөвлөгөөнд өмнөх хичээлийн уялдаа холбоог заавал тусгасан байна;

3.2.3. Техникийн боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд ерөнхий суурийн хэсэгт сургалтын хөтөлбөрийн чиглэлээс үл хамаарч хүснэгт-д үзүүлсэн агуулгын чиглэл бүрд харгалзах суралцахуйн үр дүнг эзэмшүүлэх зорилгоор хүснэгтэд заасан багц цагаас багагүй бие даасан хичээл, эсхүл хичээлийн тодорхой агуулгыг заавал судлахаар тусгасан байна;

Агуулгын чиглэл	Ерөнхий суурийн хичээлээр эзэмших суралцахуйн үр дүн	Багц цаг
Байгалийн ухаан	Байгалийн юмс үзэгдлийн мөн чанар, шинжлэх ухааны үзэл баримтлалыг ойлгож тайлбарлах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, таамаглал дэвшүүлэх, задлах шинжлэх, нэгтгэн дүгнэх Мэдээллийн технологийн ололт амжилтыг бүтээлчээр ашиглах, логик сэтгэлгээ хөгжүүлэх, шалтгаан үр дагаврын холбоог тогтоох, процессыг загварчлах, дүрслэн үзүүлэх, асуудал шийдвэрлэх	3
Хүмүүнлэгийн ухаан	Хүний хөгжлийг танин мэдэх, түүх, соёл, гүн ухаан, урлаг, гоо зүйн сэтгэлгээг хөгжүүлэх, хүний эрх, жендерийн эрх тэгш байдал, иргэний ёс зүй болон зан төлөв, хүмүүнлэг иргэн, тогтвортой хөгжлийг мэдлэг ойлголтыг хэрэглэх Эх хэлээр утга төгс ярих, илтгэх, найруулан бичих, эрдэм шинжилгээний бичлэгт хэрэглэх Англи хэл (бусад хэл)-ээр ахисан дунд түвшинд ярих, сонсох, унших, бичих, мэргэжлийн эх сурвалжийг ашиглах	6
Нийгмийн ухаан	Нийгэм, эдийн засаг, засаглал, соёлын олон талт байдал, хувь хүн, гэр бүлийн төлөвшил, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйл, хүн хоорондын харилцаа, зан үйлийг танин мэдэх, бүтээлчээр сэтгэх, асуудалд шинжлэх ухаанчаар хандах	3
Амьдрах ухаан	Эрүүл амьдрах, зөв хооллох ухаанд суралцах, бие бялдраа хөгжүүлэх, эрсдэл, гамшгийн үед аюулгүй байдлаа хангах, анхан шатны тусламж, дэмжлэг үзүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, түүний хор уршиг, дэлгэцийн донгоос сэргийлэх	3
Салбар чиглэлийн ерөнхий суурь	Сонгосон мэргэжлийн онцлог, ажлын байрны шаардлага, хөгжлийн чиг хандлага, давуу талыг тайлбарлах, мэргэжлийн чиглэлийн суурь мэдлэг, чадварыг асуудал шийдвэрлэхэд хэрэглэх, хувь хүний, харилцааны үндсэн мэдлэг, чадварыг мэргэжлийн хүрээнд хэрэглэх	-

Энэхүү шаардлагад нийцүүлэн Монголын түүх, соёл; Монгол хэл, бичиг, найруулга зүйн чиглэлийн суралцахуйн үр дүнг эзэмшүүлэх 6-аас доошгүй багц цагийн агуулгыг сургалтын төлөвлөгөөнд заавал судлахаар тусгана.

ДӨРӨВ. ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН АГУУЛГА

4.1. Чадамжийн нэгжийн танилцуулга: Чадамжийн нэр, код, чадамжийн нэгжийн хөтөлбөрийг боловсруулсан, зөвлөсөн, хянасан

багийн мэдээлэл, товчилсон үгийн тайлбар, агуулга байна.

4.2.Сайжруулсан тэмдэглэл: Тухайн хувилбарт орсон гол өөрчлөлтийн талаарх товч тайлбар.

4.3.Чадамжийн нэгжийн тодорхойлолт: Мэргэжлийн чиглэл, индекс, мэргэшлийн нэр, мэргэшлийн түвшин, чадамжийн нэгжийн салбар дахь дараалал, хувилбарыг илэрхийлсэн байдлаар тодорхойлно.

4.3.1.Чадамжийн нэгжийн тодорхойлолт: Тухайн чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшлийг товч тодорхой бичнэ;

4.3.2.Өмнө нь эзэмшвэл зохих чадамжийн нэгжийн код, нэр: Тухайн чадамжийн нэгж нь өмнөх чадамжийн нэгжүүдтэй хэрхэн холбогдох талаар тодорхойлон бичнэ.

4.4.Суралцахуйн үр дүн буюу эзэмшсэн байвал зохих мэдлэг, ур чадвар, хандлага: Суралцахуйн үр дүн бүр нь суралцах үйл явцын төгсгөлд суралцагч юу хийж чаддаг болсон бэ гэдгийг илэрхийлсэн, суралцагчийн эзэмшсэн байх ёстой чухал мэдлэг, ур чадварын хүрээг илэрхийлдэг. Суралцахуйн үр дүнг томъёолоходоо хичээлийн зорилгод нийцсэн, тухайн хичээл ямар үр дүнд хүргэхийг тодорхой заасан байх, тухайн хичээл суралцахуйн үр дүнг хэрэгжүүлэхэд хэрхэн хувь нэмэр оруулж байгааг харуулсан байна.

4.5.Чадамжийн нэгжийн агуулгын төлөвлөлт: Агуулгыг төлөвлөхдөө чадамжийн нэгж, элемент, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн агуулгын уялдааг хангаж, мэргэжлийн онцлогоос хамаарч зайлшгүй шаардлагатай алхмуудыг гүйцэтгэлийн шалгуурт тусгайлан тусгасан байж болно. Чадамжийн нэгжийн агуулга элементээс, элемент нь гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдээс бүрдсэн байна. Чадамжийн нэгж, элемент, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт нь тус бүрдээ тодорхой эхлэл, үйл явц, төгсгөл бүхий ажил, гүйцэтгэл, алхмыг илэрхийлсэн байна.

4.6.Чадамжийн нэгжийн элементийн төлөвлөлт: Чадамжийн элемент тус бүрээр төлөвлөлт хийх бөгөөд гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд суурилан эзэмшвэл зохих буюу онолоор олгох мэдлэг, дадлагаар олгох ур чадварыг сургууль дээрх дадлага лаборатори, үйлдвэрлэлийн дадлага, бие дааж хийх хэмээн аль тохиромжтой арга зүйгээр томъёолно.

4.6.1.Сургууль дээрх дадлага, лаборатори: Онолыг хэрэгжүүлэх, техникийн ур чадвар эзэмших, туршилт, судалгаа хийх орчин бүрдсэн тусгай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл бүхий лаборатори, сургалтын гадаад болон дотоод дадлагын орчин, хээрийн ажил, бодит байдалд багшийн хяналт удирдлага доор хийгдэх дадлага ажлууд орно;

4.6.2.Үйлдвэрлэлийн дадлага: Ажлын бодит үүргийг гүйцэтгэж туршлага авах, байгууллагын соёлд дасан зохицох, практик мэдлэг олж авах зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээний бодит орчинд туршлагатай ажилтнууд, дадлагажуулагч нарын удирдлага дор явагдана;

4.6.3.Бие дааж хийх дадлага: Онолын мэдлэг болон ур чадварт суралцах, бататгах зорилгоор багшийн дэмжлэггүйгээр ганцаараа болон багаараа хамтран суралцахыг хэлнэ.

4.7.Чадамжийн элементийг эзэмшүүлэхэд ашиглаж буй заах арга зүй нь мэргэжлийн онцлог болон орчин үеийн шаардлагад тулгуурласан байна.

ТАВ. ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН СУРГАЛТЫН ОРЧИН, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

5.1.Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн (машин, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, материал түүхий эд, ном, сурах бичиг, ашигласан материалын жагсаалт) нь боловсролын стандарт, мэргэжлийн болон техникийн боловсролын стандартад тусгагдсан сургалтын орчин, хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуй, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнд тавих үндсэн шаардлагыг хангасан байна.

5.2.Сургалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн, материал, түүхий эдийн жагсаалтыг сургалтын хөтөлбөрийн загвар дахь маягтын дагуу тусгасан байна.

5.3.Тухайн чадамжийн нэгжид шаардагдах ном, сурах бичгийн нэр, эх сурвалжийг тодорхой зааж хөтөлбөрт тусгана.

5.4.Сургалтын байгууллага ялгаатай хэрэгцээт суралцагчийг суралцуулах тохиолдолд онцлог хэрэгцээнд тохирох хүртээмжтэй орчныг бүрдүүлнэ.

5.5.Чадамжийн нэгж (хичээл) тус бүрээр өртөг, зардлын тооцоолол хийж сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг бүрдүүлэхэд анхаарч ажиллана.

ЗУРГАА. ҮНЭЛГЭЭ

6.1.Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн үнэлгээ нь оношлох үнэлгээ, явцын үнэлгээ, чадамжийн нэгж (хичээл)-ийн үнэлгээ, төгсөлтийн үнэлгээ гэсэн төрөлтэй байх ба үнэлгээний талаарх мэдээллийг суралцагчдад нээлттэй, ил тод мэдээлэхээр боловсруулсан байна.

6.2.Хөтөлбөрт иргэний өмнөх мэдлэг, ур чадвар хүлээн зөвшөөрөх үнэлгээний үр дүнг тооцох боломжуудыг тусгасан байна.

6.3.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын үнэлгээг зохион байгуулахад “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах журам”-ыг баримтална.

6.4. Үнэлгээ хэсэгт чадамжийн элемент нэг бүрээр тодорхойлогдсон үнэлгээний шалгуур үзүүлэлтийг эзэмшсэн эсэхийг үнэлэх аргыг тусгана.

ДОЛОО. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ҮНЭЛГЭЭ БА САЙЖРУУЛАЛТ

7.1. Сургалтын хөтөлбөрийн сайжруулалт хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад цуглуулсан нотолгоонд суурилна. Үүнд дараах үнэлгээ, шинжилгээг багтаана:

7.1.1. Төгсөгчдийн ажил эрхлэлт болон хөдөлмөр эрхлэлтийн хувь, түүнд үндэслэсэн хандлага, өөрчлөлтийн шинжилгээ;

7.1.2. Сургалтын хөтөлбөрт хийсэн өөрчлөлт, сайжруулалтын тэмдэглэл, баримт;

7.1.3. Сургалтын хөтөлбөртэй холбогдох оролцогч талууд (төгсөгч, ажил олгогч, багш, оюутан зэрэг)-ын сэтгэл ханамжийн судалгаа;

7.1.4. Сургалтын хөтөлбөрийн үр дүнг илтгэх шууд (жишээлбэл, шалгалт, төгсөлтийн ажил, үнэлгээний оноо) болон шууд бус (жишээлбэл, судалгаа, ярилцлага, төгсөгчдийн хандлага)-ын үнэлгээ;

7.1.5. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд хамрагдсан эсэх, магадлан итгэмжлэгч байгууллагын санал, зөвлөмж;

7.1.6. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн жагсаалтад орсон эсэх мэдээлэл;

7.1.7. Хөтөлбөрийн боловсролын зорилго, хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, хичээлийн суралцахуйн үр дүн зэргийг үнэлэх, тэдгээрийн уялдаа холбоо, хэрэгжилт, хүрсэн түвшинд дүн шинжилгээ хийх.

*Боловсролын сайдын 2025 оны 11
дүгээр сарын 28-ны өдрийн А/563
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт*

**Мэргэжлийн болон техникийн
боловсролын сургалтын
байгууллагын лого**

**МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР
(Загвар)**

Мэргэжлийн индекс, код:
Хөтөлбөрийн нэр:
Боловсролын түвшин:
Мэргэшлийн нэр:
Суралцах хугацаа:

Огноо

БАТЛАВ
СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН
ЗАХИРАЛ
(овог нэр, гарын үсэг, тамга)

20 ... оны ... сарын ... өдөр

БОЛОВСРУУЛСАН:

Албан тушаал

Овог, нэр

Гарын үсэг

1.

2.

3.

ЗӨВЛӨСӨН:

Албан тушаал

Овог, нэр

Гарын үсэг

1.

2.

3.

ХЯНАСАН:

Албан тушаал

Овог, нэр

Гарын үсэг

1.

2.

3.

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН БҮТЭЦ

1. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА
 - 1.1. Сайжруулсан тэмдэглэл
 - 1.2. Сургалтын хөтөлбөрийн үндэслэл
 - 1.3. Сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт
 - 1.4. Суралцахуйн үр дүн
2. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА
 - 2.1. Чадамжийн нэгжийн жагсаалт
 - 2.2. Багцлах дүрэм
 - 2.3. Хичээлийн агуулгын уялдааны зураглал
3. СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

4. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

- 4.1. Сайжруулсан тэмдэглэл
Хувилбар №2. Анхны тусламж үзүүлэх чадамжийн
нэгжийн гарчигт бичгийн засвар хийсэн.
Хувилбар №1. АМС-д нийцүүлэн ... шинэчилсэн.
- 4.2. Сургалтын хөтөлбөрийн үндэслэл
.....
- 4.3. Сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт
.....
- 4.4. Сургалцахуйн үр дүн
.....

5.СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА

5.1.Чадамжийн нэгжийн жагсаалт

д/д	Чадамжийн нэгжийн нэр	Заавал / Сонгон судлах	Чадамжийн нэгжийн код	Багц цаг
	Ерөнхий суурь			
1				
2				
3				
	Мэргэжлийн суурь			
4				
5				
6				
	Мэргэшүүлэх			
7				
8				
9				

5.2.Багцлах дүрэм

Нийт чадамжийн нэгж

о Заавал судлах – XXX

- Ерөнхий суурийн - XXX
- Мэргэжлийн суурийн - XXX
- Мэргэшүүлэх - XXX

о Сонгон судлах - XXX

- Ерөнхий суурийн - XXX
- Мэргэжлийн суурийн - XXX
- Мэргэшүүлэх - XXX

5.3.Хичээлийн агуулгын уялдааны зураглал.

6. СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

БАТЛАВ
СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН
ЗАХИРАЛ
(овог нэр, гарын үсэг, тамга)

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ (1 жил)

- Хөтөлбөрийн индекс, код:
Мэргэжлийн чиглэл/Хөтөлбөрийн нэр:
Боловсролын түвшин:
Мэргэшлийн нэр:
Суралцах хугацаа:
- Элсэгчийн боловсрол:
Сургалтын хэлбэр:
☐ Сургалтын байгууллага
☐ Ажлын байран дахь
☐ Хосмог
☐ Зайны
☐ Цахим

№	Чадамжийн нэгж (судлагдахуун)-ийн нэр	Чадамжийн нэгжийн код	Багц цаг	Нийт цаг (5+6+7)	Онол	Сургууль дээрх дадлага	Үйлдвэрлэлийн дадлага	Улирал			
								1		2	
								9	9	9	9
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Ерөнхий суурь хэсэг			5.3	198	180	18	0	0	0	0	0
1	Мэргэжлийн англи хэл		1.0	36	36						
2	Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах		1.0	36	36						
3	Энтрепренершилд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөр		1.8	72	54	18					
4	Гамшгаас хамгаалах мэдлэг олгох		0.5	18	18						
Сонгох чадамж			1.0	36	36						
5	Амьдрах ухааны ур чадвар эзэмших		1.0	36	36						
6											
7											
8											
Мэргэжлийн суурь хэсэг			0.0	0	0	0	0	0	0	0	0
9											
10											
11											
12											
Сонгох чадамж			0.0	0	0	0	0	0	0	0	0
13											
14											
15											
16											
Мэргэшүүлэх хэсэг			0.0	0	0	0	0	0	0	0	0
17											
18											
19											
20											
Сонгох чадамж			0.0								
21											
22											
31											
24											
Нийт дүн			5.3	198	180	18	0	0	0	0	0

Мэргэжлийн боловсролын агуулгын онол,
дадлагын харьцаа 30/70 (+-5)

БОЛОВСРУУЛСАН:
ХЯНАСАН:

Албан тушаал, нэр
Албан тушаал, нэр

БАТЛАВ
СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН
ЗАХИРАЛ
(овог нэр, гарын үсэг, тамга)

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ (3 жил)

Хөтөлбөрийн индекс, код:
Мэргэжлийн чиглэл/Хөтөлбөрийн нэр:
Боловсролын түвшин:
Мэргэшлийн нэр:
Суралцах хугацаа:

Элсэгчийн боловсрол:
Сургалтын хэлбэр:
☐ Сургалтын байгууллага
☐ Ажлын байран дахь
☐ Хосмог
☐ Зайны
☐ Цахим

№	Чадамжийн нэгж (судалгдахуун)-ийн нэр	Чадамжийн нэгжийн код	Балц цаг	Нийт цаг (5+6+7)	Онол	Сургууль дээрх	Үйлдвэрлэл ийн дадлага	1 дэх жил		2 дахь жил		3 дахь жил	
								I	II	III	IV	V	VI
								18	18	18	18	18	18
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
А.Бүрэн дунд боловсролын агуулга			45.5	1638	1638	0	0	0	0	0	0	0	0
1	Монгол хэл, уран зохиол		5.5	198	198								
2	Үндэсний бичиг		4.5	162	162								
3	Математик		7.0	252	252								
4	Нийгмийн судлал		3.0	108	108								
5	Монголын түүх		1.5	54	54								
6	Газарзүй		2.5	90	90								
7	Биологи		2.5	90	90								
8	Физик		2.5	90	90								
9	Хими		2.5	90	90								
10	Гадаад хэл /Англи хэл/		5.5	198	198								
11	Биеийн тамир		3.0	108	108								
12	Иргэний ёс зүйн боловсрол		2.0	72	72								
13	Мэдээллийн технологи		2.5	90	90								
14	Эрүүл мэнд		1.0	36	36								
Б. Мэргэжлийн боловсролын агуулга			6.8	252	234	18	-	-	-	-	-	-	-
Ерөнхий суурь хэсэг			6.8	252	234	18	-	-	-	-	-	-	-
1	Мэргэжлийн англи хэл		1.0	36	36								
2	Энтерпренершид суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөр		2.5	90	90								
3	Гамшгаас хамгаалах		1.0	36	36								
4	Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах		1.0	36	36								
5	Хөдөлмөрт бэлтгэх		1.3	54	36	18							
Сонгох чадамж			1.0	36	36	0	0	0	0	0	0	0	0
6													
7													
Мэргэжлийн суурь хэсэг			0.0	0	0	0	0	0	0	0	0	0	0
8													
9													
10													
11													
Сонгох чадамж			0.0	0	0	0	0	0	0	0	0	0	0
12													
13													
Мэргэшүүлэх хэсэг			0.0	0	0	0	0	0	0	0	0	0	0
14													
15													
16													
17													
Сонгох чадамж			0.0	0	0	0	0	0	0	0	0	0	0
18													
19													
	Нийт дүн		52.3	1,890	1,87	18	-	-	-	-	-	-	-

Мэргэжлийн боловсролын агуулгын
онол дадлагын харьцаа 30/70 (+5)

БОЛОВСРУУЛСАН:
ХЯНАСАН:

Албан тушаал, нэр
Албан тушаал, нэр

БАТЛАВ
СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН
ЗАХИРАЛ
(овог нэр, гарын үсэг, тамга)

ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ (1.5 болон 3 жил)

Хөтөлбөрийн индекс, код:
Мэргэжлийн чиглэл/Хөтөлбөрийн нэр:
Боловсролын түвшин:
Мэргэшлийн нэр:
Суралцах хугацаа:

Элсэгчийн боловсрол:
Сургалтын хэлбэр:
☐ Сургалтын байгууллага
☐ Ажлын байран дахь
☐ Хосмог
☐ Зайны
☐ Цахим

№	Чадамжийн нэгжийн нэр	Чадамжийн нэгжийн код	Багцаг (4+5+6+7)	Суралцахуйн үр дүн /багц цагаар/			Улирал					
				Онол	Сургууль дээрх дадлага	Үйлдвэр лэлийн дадлага	1 дэх жил		2 дахь жил		3 дахь жил	
							I	II	III	IV	V	VI
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
	Ерөнхий суурь хэсэг		15	15	0	0	0	0	0	0	0	0
1	Монголын түүх, соёл		3.0	3								
2	Монгол хэл, бичиг, найруулга зүй		3.0	3								
3	Байгалийн ухаан		3.0	3								
4	Нийгмийн ухаан		3.0	3								
	Сонгон судлах		0.0	0	0	0	0	0	0	0	0	0
5												
6												
	Мэргэжлийн суурь хэсэг		0.0	0	0	0	0	0	0	0	0	0
7												
8												
9												
10												
	Сонгон судлах		0.0	0	0	0	0	0	0	0	0	0
11												
12												
	Мэргэшүүлэх хэсэг		0.0	0	0	0	0	0	0	0	0	0
13												
14												
15												
16												
	Сонгон судлах		0.0	0	0	0	0	0	0	0	0	0
17												
18												
	Нийт дүн		15	15	0	0	0	0	0	0	0	0

Техникийн боловсролын агуулгын онол дадлагын харьцаа 40/60 (+5)

БОЛОВСРУУЛСАН:
ХЯНАСАН:

Албан тушаал, нэр
Албан тушаал, нэр

**Мэргэжлийн болон техникийн
боловсролын сургалтын
байгууллагын лого**

ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН НЭР
[чадамжийн код]
(Загвар)

Огноо

БАТЛАВ
СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН
ЗАХИРАЛ
(овог нэр, гарын үсэг, тамга)

20 ... оны ... сарын ... өдөр

БОЛОВСРУУЛСАН:

Албан тушаал

Овог, нэр

Гарын үсэг

1.

2.

3.

ЗӨВЛӨСӨН:

Албан тушаал

Овог, нэр

Гарын үсэг

1.

2.

3.

ХЯНАСАН:

Албан тушаал

Овог, нэр

Гарын үсэг

1.

2.

3.

ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН АГУУЛГЫН БҮТЭЦ

1. ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН ТАНИЛЦУУЛГА
 - 1.1.Сайжруулсан тэмдэглэл
 - 1.2.Чадамжийн нэгжийн тодорхойлолт
 - 1.3.Суралцахуйн үр дүнгүүд
2. ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН АГУУЛГЫН ТӨЛӨВЛӨЛТ
3. ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН ЭЛЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨЛТ
 - 3.1.Чадамжийн элемент 1:
 - 3.2.Чадамжийн элемент 2:
4. ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН СУРГАЛТЫН ОРЧИН,
ХЭРЭГЛЭГДЭХҮҮН
 - 4.1.Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн
 - 4.2.Материал, түүхий эдийн жагсаалт:
 - 4.3.Ном, сурах бичиг, ашигласан материал:
5. ҮНЭЛГЭЭ

1.ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Сайжруулсан тэмдэглэл

Хувилбар №2.

Хувилбар №1.

1.2. Чадамжийн нэгжийн тодорхойлолт

Чадамжийн нэгжийн нэр, код:	
Чадамжийн нэгжийн тодорхойлолт:	
Өмнө нь эзэмшвэл зохих чадамжийн нэгжийн код, нэр:	

1.3. Суралцахуйн үр дүнгүүд

Мэдлэг:

-
-

Ур чадвар

-
-

Хандлага

-
-

2.ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН АГУУЛГЫН ТӨЛӨВЛӨЛТ:

№	Чадамжийн элемент	Анги дүүргэлт:			
		Сургалтын цаг:			
		Онол	Дадлага		Нийт цаг
			Сургууль дээрх	Үйлдвэрлэл дээрх	
1.					
2.					
3.					
	Дүн				
	Онол/дадлагын харьцаа, хувиар				

3.ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН ЭЛЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨЛТ

3.1.Чадамжийн элемент 1:

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
ГШҮ 1. ...	
ГШҮ 2. ...	
Мэдлэг:	
...	
...	
...	
Ур чадвар:	
Сургууль дээрх дадлага, лаборатори:	
Үйлдвэрлэлийн дадлага:	
Бие дааж хийх дадлага:	

3.2.Чадамжийн элемент 2:

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
ГШҮ 1. ...	
ГШҮ 2. ...	
Мэдлэг:	
...	
...	
...	
Ур чадвар:	
Сургууль дээрх дадлага, лаборатори:	
Үйлдвэрлэлийн дадлага:	
Бие дааж хийх дадлага:	

4.ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН СУРГАЛТЫН ОРЧИН, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

4.1.Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн

№	Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Тайлбар, зориулалт
А. Машин, техник хэрэгсэл				
1				
2				
3				
Б. Тоног төхөөрөмж				
1				
2				
3				
В. Багаж хэрэгсэл				
1				
2				
3				

4.2.Материал, түүхий эдийн жагсаалт:

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тайлбар, зориулалт
1			
2			
3			

4.3.Ном, сурах бичиг, ашигласан материал:

Ном, сурах бичиг, хэрэглэгдэхүүн

1. ...

2. ...

Хууль, тушаал шийдвэр, норм стандарт

1. ...

2. ...

Машин, техник хэрэгсэл, Тоног төхөөрөмж, Багаж хэрэгслийн үйлдвэрлэгчийн гэрчилгээ, техникийн паспорт, засвар үйлчилгээний заавар

1. ...

2. ...

Цахим, программ хангамж, бусад

1. ...

2. ...

5. ҮНЭЛГЭЭ

Чадамжийн элемент буюу суралцахуйн үр дүн	Үнэлгээний шалгуур үзүүлэлт	Үнэлгээний арга					
		Ажиглалт	Сорил арга	Эцсийн бүтээгдэхүүнийг үнэлэх арга	Гуравдагч талын нотолгоо	Бие даалт, курсын ажил	Асуулт ярилцлагын арга
		+	+	+			+

--- o0o ---

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 1 дүгээр сарын 05-ны өдрийн 7469 дүгээрт бүртгэв.

ГОВЬСҮМБЭР АЙМАГ БАЯНТАЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 07

Баянтал сум

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 35.1.17, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, 52 дугаар зүйлийн 52.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, 64 дүгээр зүйлийн 64.6, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.2023-2024 онуудад сумын хэмжээнд өвөлжилт, хаваржилтийн нөхцөл байдал хүндэрч мал олноор хорогдож байгаа тул малчид, мал бүхий этгээдийн амьжиргааг дэмжих зорилгоор малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг таван төрөл тус бүрд 0 төгрөг байхаар тогтоосугай.

2.Малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг тогтоох тухай тогтоолыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, нийтэд сурталчилж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөд тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 09 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б.МӨНХ-ЭРДЭНЭ

ДОРНОГОВЬ АЙМАГ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРАЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 08/16

Сайншанд сум

ТОГТООЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.4, 35 дугаар зүйлийн 35.1.10, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь заалт, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхэлж орлого олж байгаа хувь хүний сард төлөх татварын хувь хэмжээг тогтоосон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12/08 дугаар тогтоолын хавсралтад дараах өөрчлөлт оруулсугай.

1.1.Сард ногдох албан татварын хэмжээ төгрөгөөр илэрхийлсэн хэсэг, албан татварын хувь хэмжээг тухайн жилийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцохын “11-ээс дээш удаа гарвал 50 хувь” гэснийг хассугай.

1.2.Албан татварын хувь хэмжээг тухайн жилийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцохын “3-10 удаа гарвал” гэснийг “1-ээс дээш удаа гарвал” гэж, “30 хувь” гэсэн хэмжээг “15 хувь” болгон өөрчилсүгэй.

2.Энэхүү тогтоолын нэмэлт өөрчлөлтийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолын нэмэлт өөрчлөлтийг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдөж, хэрэгжилтийг зохион байгуулан, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Батжаргал)-д үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төсөв санхүү эдийн засгийн хөгжлийн хорооны ахлагч (Л.Наранхүү), аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ц.Батсугир) нарт тус тус даалгасугай.

ДАРГА

Н.АЛДАРБАЯР

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 11 дүгээр
сарын 28-ны өдөр

Дугаар А/310

Улаанбаатар
хот

ТОГТООЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ

Боловсролын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.13, 17.14, 17.15 дахь заалтыг хэрэгжүүлэх, Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Бүтэц, дүрэм батлах тухай” 2023 оны 12 дугаар сарын 27 ны өдрийн А/593 дугаар тушаалаар батлагдсан “Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл”-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.5, 4.6.4 дэх заалт, Боловсролын сайдын 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/559 тоот “Журам, шаардлага батлах тухай” тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх журам” батлагдсантай холбогдуулан магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаанд мөрдөж байсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн удирдах зөвлөл”-ийн 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам, шалгуур шаардлага батлах тухай” 08 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцугай.

2.Магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаанд “Мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх журам”-ыг мөрдөж ажиллахыг Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

Б.АМАРСАНАА

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр хүлээн авсан.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны 1 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар А/05,17

Улаанбаатар
хот

ЗАРДЛЫН НОРМАТИВ, АРГАЧЛАЛ БАТЛАХ ТУХАЙ

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын норматив, санхүүжүүлэх аргачлал”-ыг хавсралтаар баталсугай.

2.Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг аргачлал, нормативын дагуу санхүүжүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алимаа, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Чинбат/-д тус тус даалгасугай.

3.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Аргачлал, зардлын норматив батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтран баталсан 2022 оны А/23, 27 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 12 дугаар
сарын 03-ны өдөр

Дугаар А/225

Улаанбаатар
хот

ТУШААЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/180 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хүүхэд харах үйлчилгээний шалгуур, болзол, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих журам”-ын дөрөв.“Үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, хугацаа сунгах, хүчингүй болгох” бүлгийг хүчингүй болсонд тооцсугай.

2.Энэхүү тушаалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газар (Д.Мөнгөнтуул), Гэр бүлийн бодлогын газар (Ц.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

САЙД

Т.АУБАКИР

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр хүлээн авсан.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2025 оны 12 дугаар
сарын 03-ны өдөр

Дугаар А/226, А/211

Улаанбаатар
хот

ТУШААЛ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Журам батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/05, А/17 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

2.Хүчингүй болсон тушаалыг холбогдох журмын дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангаас хасуулах арга хэмжээ авахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн захиргааны удирдлагын газар (Д.Мөнгөнтуул)-т даалгасугай.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙД

Т.АУБАКИР

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

ТЭМДЭГЛЭЛ